



2018 ОНЫ МОНГОЛ-ЯПОНЫ ТӨВИЙН ЯПОН ДАХЬ ДАДЛАГА СУРГАЛТЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа 2018.09.02 - 2018.09.15

2018 он

Сургалтын хөтөлбөр

Сургалтын нэр:	Бизнесийн удирдлагын дадлага сургалт Practical Business Administration
Хугацаа:	9/2/2018 - 9/15/2018

Сургалтын зорилго:	Үндсэн сургалтын лекц, хэлэлцүүлгээр суралцсан мэдлэгээ Японд бодит байдалтай нь танилцаж, ЖДҮ эрхлэгчид ямар менежментийн стратегит тулгуурлан бизнесийн үйл ажиллагаагаа эрхэлж байгаа зэргээс сурч, лекц хэлэлцүүлгээр баяжуулан батжуулж, ойлголтоо гүнзгийрүүлэн, компанийхаа үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн Action plan хөтөлбөр боловсруулах. Японы бизнес эрхлэгчидтэй хамтын ажиллагаа тогтоож, ирээдүйд гадаад зах зээлд нэвтрэх ба гадаад хамтын ажиллагаа тогтооход шаардлагатай мэдлэг, мэдээлэл олж авах.
Сургалтын агуулга:	<p>1.Японы ЖДҮ-үүдийн бодит байдалтай танилцаж, Япон компанийн захирлуудтай ярилцаж, Монголд лекц, хэлэлцүүлгээр суралцсан Япон маягийн менежмент /Менежментийн стратеги, маркетинг, хүний нөөцийн удирдлага зэрэг/-ийн ойлголтоо гүнзгийрүүлэх.</p> <p>2. Үйлдвэрлэлийн салбар: Үйлдвэрлэлийн байр, газар дээрх кайзэн-сайжруулалт, ажилчдын сургалт хөгжүүлэлт, менежментэд шаардлагатай мэдээлэл олж авах, мэдлэг эзэмших Үйлчилгээний салбар: Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг хангахад шаардлагатай үйлчилгээний сайжруулалт, ажилчдын сургалт, хөгжүүлэлт, менежментэд шаардлагатай мэдээлэл олж авах, мэдлэг эзэмших</p> <p>3.Бизнесийн уулзалтад оролцож, японы бизнес эрхлэгчидтэй санал солилцох.</p> <p>4.Дадлага сургалтаар эзэмшсэн мэдлэг, олж авсан мэдээллээр өөрийн үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн Action plan хөтөлбөр боловсруулах.</p>
Сар өдөр	Сургалтын агуулга
9/2(Sun)	Токиод ирэх
9/3(Mon)	ЖАЙКА чиглүүлэх уулзалт
	ЖАЙКА товч танилцуулга
	Чиглүүлэх сургалт/Асуудал хэлэлцүүлэг
	Сэдэлжүүлэх лекц: Хүнд ээлтэй менежмент
9/4(Tue)	Тоёота хэлбэрийн 4S-ийг хэрэгжүүлэх нь
	Байгууллагын хөгжил ба хүний нөөцийн сургалт, хөгжүүлэлт
	Сүлжээ рестораны найрсаг зочломтгой үйлчилгээтэй танилцах
9/5(Wed)	Чемодан илгээх
	Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа: Хуванцар сав дахин боловсруулах үйлдвэр үзэж танилцах
	Бизнес уулзалт Семинар ①Монголын бизнесийн орчны тухай танилцуулга
	Бизнес уулзалт Семинар ②Монголын хууль, эрх зүйн лекц
	Бизнес уулзалт Монгол компаниудын танилцуулга
9/6(Thu)	Токио- Нагояа
	Тоёотагийн үйлдвэрлэлийн аргачлал /систем/

	Нагоя-Оосака
9/7(Fri)	Менежментийн стратеги, бүтээгдэхүүн хөгжүүлэлт
	Менежментийн философи, маркетинг
	Дэлгүүрийн үйл ажиллагаа
9/8(Sat)	Бие даалт
9/9(Sun)	Бие даалт
9/10(Mon)	Давтлага
	Бизнес уулзалт Семинар ① Монголын бизнесийн орчны тухай танилцуулга
	Бизнес уулзалт Семинар ② Монголын хууль, эрх зүйн лекц
	Бизнес уулзалт Бизнесийн хамтын ажиллагаа
	Бизнесийн уулзалтад оролцохгүй суралцагчид: Японы алдартай бизнесменээс суралцах Менежментийн философи ба үйлдвэрлэл
9/11(Tue)	Үйлчилгээний салбар Ажлын байранд хэрэгжүүлэх кайзэн-сайжруулалт, 3S хөдөлгөөн
	Үйлчилгээний салбар Менежментийн философи, маркетинг
	Үйлдвэрлэлийн салбар 3S-ийг үзэл баримтлал болгосон менежментийн ухаан
	Үйлдвэрлэлийн салбар Үйл ажиллагааны стратеги ба дэлгүүрийн ажилтны сургалт, хөгжүүлэлт
9/12(Wed)	Үйлчилгээний салбар Менежментийн стратеги, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж
	Үйлчилгээний салбар Менежментийн төлөвлөгөө, ажиллагсдын сэтгэл ханамж, брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэлт
	Үйлдвэрлэлийн салбар Менежментийн стратеги, хүний нөөцийн сургалт, хөгжүүлэлт, ур чадварын менежмент
	Үйлдвэрлэлийн салбар Менежментийн стратеги, брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэлт
9/13(Thu)	Онол, зарчимд үндэслэсэн кайзэн-сайжруулалт хөдөлгөөнийг хэрэгжүүлэх арга
	Онол, зарчимд үндэслэсэн кайзэн-сайжруулалт хөдөлгөөнийг хэрэгжүүлэх арга
	Үр дүнгийн тайлан хурлын бэлтгэл
9/14(Fri)	Үр дүнгийн тайлан хурал ①
	Үр дүнгийн тайлан хурал ②
	Үнэлгээний хурал
	Төгсөлт
9/15(Sat)	Монгол руу буцах

“ЧИГЛЭЛ” ХХК

Нэр: Ц.Бумцэнд
Албан тушаал: Ерөнхий захирал
Үндсэн сургалт төгссөн он: 2017



Компанийн нэр	Чиглэл ХХК
Байгуулагдсан он	1990
Үйл ажиллагааны чиглэл	Хүнс, нийтийн хоолны зориулалтын тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, худалдаа, засвар үйлчилгээ
Ажилчдын тоо	46

Компанийн товч танилцуулга

Манай компани анх 1990 онд гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, нийтийн хоолны тоног төхөөрөмжийн засвар, угсралтын чиглэлээр үйл ажиллагаагаа явуулахаар Чиглэл БХХоршоо нэртэйгээр үүсгэн байгуулагдсан.

1998 оноос Чиглэл ХХК нэртэйгээр өргөжин тэлж дэлгүүр, цайны газар, ресторан, бар, эмнэлэг, цэцэрлэг, сургууль, амралт сувилал зэрэг газруудын гал зуухны тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ угсралт худалдаа нийлүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Манай байгууллага аймаг орон нутгийн бүртгэлтэй ажилчид өргөнөөр хамруулж ажил олгодог.



2005 онд БНХАУ-аас тоног төхөөрөмж үйлдвэрлэх машин техник, багаж оруулж ирснээр байгууллагуудын захиалгаар 1,2,4 ширэмтэй духовктай духовкгүй цахилгаан зуухнууд, хоол халуун байлгагч, олон төрлийн газын зуухнууд, гурил хайрагч, хэвийн боов чанах тогоо, тос шүүгч, цэвэр ус нөөцлөх сав, буузны цахилгаан жигнүүр, сүү боловсруулах цехийн жижиг оврын төхөөрөмж, төрөл бүрийн хэмжээтэй нержин тавцантай бэлтгэлийн ширээнүүд, тавиур, тавцан зэрэг 20 гаруй нэр

төрлийн тоног төхөөрөмж үйлдвэрлэхийн зэрэгцээ сүү хөөрүүлэх, ариутгах, хөргөх, тараг бүрэх, шөлтэй хоол хийх, цай чанах, мах чанах, аарц буцалгах, жимс жимсгэнэ чанах, бууз жигнэх зэрэг 10 гаруй үйлдэлтэй цахилгаан тогоог 60, 80, 100 литрийн багтаамжтайгаар, цахилгаан бага зарцуулахаар зохион бүтээж, Монгол улсын брэнд бүтээгдэхүүн болгохоор дотооддоо үйлдвэрлэн, импортыг орлох, гадагш гарах мөнгөний урсгалыг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэрийг дэмжих, үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэх зорилт тавин мэргэжлийн инженер техникийн чадварлаг баг амжилттай ажиллаж байна.

Манай компани ОХУ, БНХАУ-аас хүнс нийтийн хоол, бар рестораны зориулалтын тоног төхөөрөмжийг импортлон өөрийн 5 салбар дэлгүүрүүдээр баталгаат хугацаатай

худалдан борлуулж, засвар үйлчилгээг чанартай хийж, сэлбэг хэрэгслээр хангаж, угсарч суурилуулахын зэрэгцээ хуучин тоног төхөөрөмж сэргээн засварлах, ашиглагдсан тоног төхөөрөмжийг худалдаалах дагнасан дэлгүүр ажиллуулж байна.

Манай компани мэргэжлийн үйл ажиллагааг олон жил, тасралтгүй, тогтвортой явуулж ирсэн, олонд танигдсан, хүнс нийтийн хоолны салбартаа тэргүүлэгч хамт олон болсон бөгөөд МҮХАҮТ-ын гишүүн, “Баялаг бүтээгчдийг дэмжих” холбооны гишүүн байгууллага юм.

Манай компанийн дотооддоо үйлдвэрлэдэг гол нэрийн бүтээгдэхүүнүүд

2-р хоолны тогоо



4 ширэмтэй цахилгаан зуух



Намуунзаяа олон үйлдэлт 1-р хоолны тогоо



Бэлтгэлийн ширээ



НЭГ. Япон дахь бизнес сургалтад суух болсон шалтгаан

1. Менежментийн талаар онолын цогц мэдлэгтэй болох
2. Компанидаа япон маягийн менежментийг бүрэн хэрэгжүүлэх

ХОЁР. Бизнесийн үндсэн сургалтанд сурсан зүйлээ компанидаа яаж хэрэгжүүлсэн бэ? Компанид гарсан өөрчлөлт

3S хөдөлгөөний идэвхжүүлэлтийн талаар

3S анхан шатны мэдэгдэхүүнтэй болсон. Япон менежментийн талаар анхан шатны мэдэгдэхүүнтэй болсноор компаний үйл ажиллагаанд багахан өөрчлөлт оруулсан.



ГУРАВ. Дадлага сургалтын зорилго буюу Японоос суралцах зүйлс

- ❖ Чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх **ОНОВЧТОЙ** системийг судалж Японы техник технологийн шийдлийг өөрийн үйлдвэрлэж буй бараа бүтээгдэхүүнд хэрхэн

нэвтрүүлж болох боломжийг судлах мөн өөрийн үйлдвэрлэдэг бүтээгдэхүүнээ Японы зах зээлд нийлүүлэх судалгаа, арга замыг хайх

- ❖ Японы компаниуд чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд 5S хэрхэн хэрэгжүүлдэг, хүний нөөцөө хэрхэн бэлтгэдэг, сургадаг, хөгжүүлдэг зэргийг судлах
- ❖ ЗАРДЛЫГ хэрхэн **БУУРУУЛАХ** систем, Кайзэнг хөгжүүлэх, шинэ санаа санаачилгыг оновчтойгоор **УДИРДАХ**-д суралцах
- ❖ Япон хүний зан заншил, түүх дурсгал, хоолны үйлдвэрлэл, үйлчилгээний соёл, хүмүүжил, техник технологийн хөгжил, хотжилт зэргээс судлах, сонирхох

Туршлага судалсан япон компаниудын нийтлэг онцлог:

- ❖ Бүх компаниуд **Хүн төвтэй менежментийг** бий болгосон .
- ❖ Компанийн бүхий л үйл ажиллагаа нь япон хүний сайн сайхны төлөө чиглэсэн байдаг.
- ❖ 3S-5S-ийн системд тулгуурласан менежментийн зарчмыг хэрэгжүүлдэг, түүнийг хэвшил болгосон.

Багаараа ажиллаж, нийгмийн нийтлэг хөгжлийн үнэ цэнийг бий болгож, хувь хүн, компани бусдад аль болох дараа болохгүй гэсэн зарчмыг баримталдаг.

Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл:

Бидний суралцах: ТАНАКА ТЕК-түүнээс хэрэгжүүлэх ажлууд, бусад компаниудын менежмент

- ❖ Киото мужын Киото хотод байрлах байгуулагдаад 78 жил болж байгаа компани. Энэхүү компани нь 1940 оны 2 сарын 1-нд байгуулагдсан. Нийт ажиллагсдын тоо 34, хөрөнгийн хэмжээ 34,000,000 иэн, үйлдвэрлэлийн нийт талбай 1450м².
- ❖ **Менежментдээ эрхэмлэдэг зүйл** : Энэхүү компани нийгэмд хэрэгтэй хүнийг бэлтгэхийг зорьж ажилладаг ба бусад хүмүүс аз жаргалтай амьдрахад тус дэм болохын тулд хүнээ хүндэтгэдэг менежментийн үнэ цэнийг бий болгоно гэж үздэг.
- ❖ Энэхүү компаниас **3S** хэрэгжүүлсэн 30 жилийн туршлагаас үргэлжлүүлэн суралцаж, сургалтын явц, технологийн дэвшил, үйлдвэрлэлийн зохион байгуулалт, тоног төхөөрөмжийн суурилуулалт, агааржуулалт, гэрэлтүүлэг, цахилгааны монтаж зэргийг ямар технологиор байршуулснаас суралцаж өөрийн компанийн шинээр ашиглалтанд орох үйлдвэрээ яг үүнтэй ижил үйлдвэр болгох зорилт тавьж байна. Хэрэглэгч тус бүрийн хэрэгцээг хангахад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хэрэглэгчийн захиалгаас хэзээ ч үгүй гэж татгалздаггүйг, хэрэгжүүлж ажиллана. **Хугацааг 2018.11.01-ээс эхлэн 2 жилийн хугацаанд**
- ❖ **Микихаус** компанийн шинэ худалдагч, худалдагч нараа хэрхэн сургадаг, үйлчлүүлэгч нараа хэрхэн судалдаг, дэлгүүрийн борлуулалтын төлөвлөгөөг хэрхэн гаргах,
- ❖ Гогёфүкү компанийн **үйлдвэргүй үйлдвэрлэгч** бизнесийн загвараас суралцсан.
- ❖ **Тоёото компанийн** үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцсан. Санпак ХК-ийн шинэ бүтээгдэхүүн бүтээж, түүнийг зах зээлд хэрхэн борлуулах тухай, хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэртэй танилцаж хогийг ялгаж савлан яаж түүхий эд болгож ашигладаг тухай зэрэг олон япон компаниудаас туршлага судлан лекц сонслоо.

Хүнийг хөгжүүлж чаддаггүй компанид хөгжил гэж байдаггүй. Нүдээр харж хянаснаар мэдээллийг хүн бүр олж авч чаддаг.

3S нь өглөө оройд өдөр бүр 5 минутын хугацаанд өөрийн ажлын байранд эрэмбэ, эмх цэгц, цэвэрлэгээг хийх, долоо хоног бүрийн сүүлийн өдөр 15 минутын хугацаагаар Кайзэн хийх, долоо хоногт 2 удаа орон нутгийн үйлдвэрлэлийн эргэн тойрныг цэвэрлэх.

ДӨРӨВ. Цаашид хэрэгжүүлэхийг хүсэж буй үйл ажиллагааны агуулга /Компани эсвэл өөрийн бие/

- ✘ Өөрчлөлтийг өөрөөсөө эхлэж, шинээр ажилд орж байгаа ажилтанд анхан шатны танилцуулах сургалт хийх, тухайн ажлын байранд нь дадлагажуулах ажилтанд дагалдуулан ажилдаа дасан зохицох хөтөлбөр боловсруулахаар төлөвлөж байна.

3S хэрэгжүүлсний үр дүн

✘ **3S - ээр өөрчлөгдөх компанийн соёл**

- ✘ 1. Хүчээр хийхээс ангижирч “Хийвэл чадна” гэсэн соёл хэрэгжинэ, Мүда-г хэрэгжүүлснээр шаардлагатай юмыг шаардлагатай цагт нь шаардлагатай хэмжээгээр үйлдвэрлэх, тээвэрлэх, борлуулах
- ✘ • Хийвэл заавал үр дүн гарна, хэвийн байх нь мэдээжийн асуудал, хэвийн бус асуудалд хяналт тавьдаг тогтолцоог хэрэгжүүлж, Кайзэн нь төгсгөл гэж байхгүй учир тасралтгүй хийж, шинэ эрэлт хэрэгцээгээр Кайзэнг хэрэгжүүлж Мүдаг нэгд нэгэнгүй арилгаж үр дүнг ил болгоно.
- ✘ 2. “Ганцаараа хийх”- ээс ангижирч, “Багаараа хийх соёлыг хэвшүүлж багийн ажиллагааг сайжруулах нь хүнийг бий болгон хөгжүүлж, хүн бий болно гэдэг нь бие хүнийг бий болгоно гэсэн ойлголтыг компанидаа хэрэгжүүлнэ.
- ✘ • 3S-ийг хэрэгжүүлснээр хүний хандлага өөрчлөгдөж, зөв хүн төрүүлж байгаа нь нийгэмд оруулж байгаа тухайн компанийн томоохон хөрөнгө оруулалтын нэг гэж ойлгон үндсэн үйл ажиллагаараа дамжуулан нийгмийн нийтлэг үнэ цэнийг бий болгож, ингэснээр өөрийн компанийн үйл ажиллагааг ашигтайгаар явуулж чаддаг компанийг үнэхээр үнэ цэнэтэй компани мөн гэсэн ухагдахууныг бий болгоно.

✘ **ЭРЭМБЭ - ЭМХ ЦЭГЦ**

- ✘ • Хаях нь хайран биш - Тавих газар, хайх цаг нь хайран байгааг олж харах.
- ✘ • 100 удаа хаясан ч дараа нь хэрэг болох нь ихдээ л 1 удаа байдаг.
- ✘ • 1 удаагийн “Хаясан чинь хэрэг болсон” -ыг биш 99 удаагийн “Хаясан нь оносон” - ыг анзааръя.”
- ✘ • Таныг юмаа хайж байх хооронд шууд ажлаа эхэлж чадсан хүн аль хэдийнээ ажлаа дуусгасан байдаг.
- ✘ • Буцааж тавихад хялбар биш л бол эцэстээ замбараагүй хөглөрөх болно. Иймд эрэмбэ, эмх цэгц.

✘ **ЦЭВЭРЛЭГЭЭ**

- ✘ * Хэний ч чадах зүйлсийг хэнээс ч илүү хийхийг 3S хэрэгжүүлэх гэнэ. Өдөр тутмын өглөө оройн цэвэрлэгээ, долоо хоног тутмын цэвэрлэгээ, сар тутмын цэвэрлэгээг хүн бүр өөрийн ажлын байранд тогтмол хийснээр цэвэр орчин бий болгож, тоног төхөөрөмж багаж хэрэгсэл эмх цэгцтэй байснаар хөдөлмөрийн бүтээмж дээшилнэ.

✘ **ХЭВШИЛ**

- ✘ 3S-ийг хэрэгжүүлж чадвал хэвийн бус байдлыг нүдээр хараад л мэднэ. Хэвшил гэдэг нь тогтсон зүйлийг байнга хэрэгжүүлэх дадал зуршлыг бий болгохыг хэлнэ. Сайн дадал зуршлыг хэвшил болгосон хүн, компани нь энэ нас түүхэн замналдаа заавал хожно. Муу дадал, муу зуршлыг бий болгосон хүн, компани энэ нас, түүхэн замналдаа байнга хохирно гэдэг ухагдахууныг компанийн цагаан шугам гэж чухалчлан анхаарч хэвшил болгон ажиллана.

ТАВ. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

- ✘ **Сургалтын нэгдсэн хөтөлбөр боловсруулан, сургалтууд зохион байгуулж эхэлсэн.**

Хүнээ байнга, тасралтгүй сургах хэрэгтэй ба үүний тулд компанийнхаа нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан гаргаж, хэрэгжүүлж эхлээд байна. Сургалтын төлөвлөгөөндөө, зөвхөн

мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэхээс гадна, 3S сургалтын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлж эхлэх, 3S-ийн самбартай болох, дүгнэх

✘ **3S-г бүрэн хэрэгжүүлэхээр зохион байгуулалтууд хийж байна.**

Нийт ажилчдаа 5, 8 хүнтэйгээр 6 баг болгон хуваах, хариуцах хэсэг хэрэгжүүлэх цаг, хяналт тавих зэргийг тодорхой болгож ажиллахаар төлөвлөгөөндөө тусгахаар төлөвлөж байна. Өдөр бүр өглөө, орой 5 минут, долоо хоногийн Баасан гарагт 20 минут хийнэ. 3S хороо байгуулж, хороо нь сар бүр хэрэгжилтийг хянаж шалгана. Шалгах хүснэгтийг сайжруулж хүснэгтийн дагуу шалгана.

- ✘ Үйлдвэрлэж байгаа бараа бүтээгдэхүүнээс чанарын доголдолтой бараа, үйлчилгээний явцад гарсан гомдол саналыг бүртгэлжүүлж, түүнд дүн шинжилгээ хийн ажиллаж эхлээд байна.

ЗУРГАА. Сургалтын талаарх сэтгэгдэл, компанид хэрэгжүүлж болохуйц жишээ

- ✘ Сургалт маш үр өгөөжтэй, үр дүнтэй болсон. Сургалтыг явуулахдаа компанийн захирлууд нь голчлон зааж үйлдвэрлэлээ танилцуулах сургалт хийсэн нь оновчтой байсан. Харин сургалтын хөтөлбөрийн орчуулга утга зүйн хувьд авцалдаагүй муу байсан.
- ✘ Японы компаниуд нь сайжруулалтыг /Кайзэн/ тасралтгүй хийснээр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, компани нь он удаан жил оршин тогтнодог гэдгийг ойлгож мэдсэн.

ДОЛОО. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

- Сургалтад ойлгож авснаа богино хугацаанд хэрэгжүүлэхийг хичээх хэрэгтэй. Хугацаа алдах тусам мартагдаж сарнидаг юм. Иймд хийх ажлаа төлөвлөж сайтар боловсруулан туушдаа хэрэгжүүлэхийн тулд багаараа ажиллах ёстой.
- Сургалтад суусан гарын авлагаа байнга нээж харж, уншиж мөн хамт суралцсан хүмүүстэйгээ байнгын харилцаатай байж, санал солилцож байх хэрэгтэй.

Танака Тек: 3S хэрэгжүүлсэн жишээ





Мики Хаус үйл ажиллагааны стратеги

❖ ХҮҮХЭД БА ГЭР БҮЛИЙНХНИЙ ӨДӨР БҮРИЙН АМЬДРАЛЫГ ИНЭЭМСЭГЛЭЛЭЭР ДҮҮРГЭХ



Тоёото компани үйлдвэрлэлийн аргаар өндөр чанартай автомашиныг үйлдвэрлэдэг.



“ТАХЬКО” ХК

Нэр: **Б. Сольрагчаа**
Албан тушаал: **Ерөнхий нягтлан бодогч**
Үндсэн сургалт төгссөн он: **2018**




Компанийн нэр:	Тахько ХК
Байгуулагдсан он:	1992
Үйл ажиллагааны чиглэл:	Үл хөдлөх хөрөнгийн түрээс, үйлчилгээ
Ажилчдын тоо:	34

Компанийн товч танилцуулга

Монгол улсад анхны оёдлын артель 1931 онд Улаанбаатар хотод байгуулагдсанаар Тахько хувьцаат компанийн тулгын чулуу тавигдсан бөгөөд уг артель бусад оёдлын артельтай нэгдсэнээр 1951 онд оёдлын 6 дугаар артель, 1970 онд оёдлын фабрик нэртэй болж үйлдвэр хоршооллын системд харьяалагдан ажиллаж байгаад Монгол улсын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1992 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 32 дугаар тогтоолоор хувьчлагдах шийдвэр гарч, Тахько хувьцаат компани (100 хувь хувийн өмчид шилжсэн) болсон.

Тахько хувьцаат компани байгуулагдсан үеэс эхлэн АНУ-ын Amerex Inc, London fog Inc, Pacific Trail Inc, Weear Guard, Turbo Sportwear зэрэг олон худалдан авагч, захиалагчаас захиалга авч, “Монголд үйлдвэрлэв” гэсэн шошготойгоор “СMP-cutting, making, paking” үнээр үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулж, АНУ, Европын зах зээлд экспортлох үйл ажиллагааг амжилттай явуулж ирсэн.

Тахько ХК Монгол улсын үндэсний оёдлын үйлдвэрлэлийг дангаараа амжилттай гүйцэтгэж байсан боловч 1999 оноос оёмол бүтээгдэхүүний захиалгад өрсөлдөөн нэмэгдэж, нэгж бүтээгдэхүүнд төлөх үйлчилгээний үнэ буурсан нь тус компанийн болон манай улсын бусад оёдлын үйлдвэрийн үйл ажиллагаанд нөлөөлж, оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн бизнес явцгүй болсноор оёдлын үйлдвэрлэлийн үйл ажиллагааг зогсоож, 2000 оноос эхлэн өөрийн байранд төрөл бүрийн ажлын байр бий болгох, үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйл ажиллагаа явуулж эхэлсэн.



1. Монгол-Японы төвийн Бизнесийн үндсэн сургалтад суух болсон шалтгаан

- Одоогоор манай компани түрээсийн үйл ажиллагаа гэсэн ганц салбарт үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд цаашид бизнесээ өргөжүүлэх, шинэ төсөл хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэх, үүний тулд судалгаа шинжилгээ, төлөвлөгөөг маш нарийн тооцоолох шаардлагатай. Мөн одоогийн компанийн санхүү болон хүний нөөцийн бодлогыг сайжруулах тал дээр анхаарч ажиллах шаардлагатай.
- Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд хөрөнгө оруулагч татах, бизнесийн шинэ хамтрагч, түншүүдтэй холбоо тогтоон хамтарч ажиллах хүсэлтэй байна.

2. Бизнесийн үндсэн сургалтад сурсан зүйлээ компанидаа яаж хэрэгжүүлж байна вэ? Компанид гарсан өөрчлөлт

Бизнес сургалтад сууснаар компанийн одоогийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсийг хамт олноороо хэлэлцэн, зорилго чиглэлдээ нийцсэн алсын хараа, эрхэм зорилготой болохоор ажиллаж байна. Санхүүгийн тайланд шинжилгээ хийх шинэ аргачлалтай болсон. Маркетингийн хичээлийн дагуу компани ямар түвшинд байгаагаа тодорхойлж, цаашдын үйл ажиллагаанд анхаарч ажиллаж байгаа. Хүний нөөцийн бодлогод нэлээд өөрчлөлтийг хийж эхлээд байна.

3. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл



Компанийнхаа эрхэм зорилго, зорилт, үнэт зүйл, алсын харааг хамтарч сайн боловсруулах, түүнийгээ ажилчдадаа сайн ойлгуулах, ажилчид нь ажлынхаа үр дүнг мэдэрч, түүнээсээ урам зориг авч “Жаргалтай компани” болдог.

Хэрэглэгчдийн хүсэл сонирхлыг маш сайн анзаарч харснаар тэндээс шинэ бүтээгдэхүүний болон хөгжүүлэлтийн санааг олж авдаг.



Өөрсдийн давуу талаа маш сайн ашигла, бусдаас суралцаж өөрсдөө мэргэш.



Эхэлснээ шантарч орхилгүй үргэлжлүүл. Бэрхшээлийн цаана амжилт байдаг.

Хүний үнэ цэнэтэй цаг хугацааг ямар нэгэн алдаа дутагдалтай бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулахгүй байх.



Японы ард түмний өв уламжлал, үнэт зүйлс, түүхээ хайрлан хамгаалж, бусдад түгээн дэлгэрүүлж байгаа байдал

4. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

Toyota L&F



4S+1S

Ашгийн эх үндэс нь эрэмбэ, эмх цэгц, цэвэрлэгээ, цэвэр цэмцгэрт оршино. Үүнийг хэвшүүлж чадвал ямар ч МҮДА гарахгүй.

Нэг Мүда дараагийн Мүда гарах үндэс болдог. Тиймээс хуурай алчуурыг ч дахин дахин мушгих хэрэгтэй.

Зүгээр хөдлөх биш үр ашигтай хөдөл

AP компани



Байгууллагын ажилчид нэг баг байх ёстой. Ажилчдыг сэтгэл ханамжтай байж ажлынхаа үр дүнг мэдрэх, ажлын жаргалтай компани болох нь амжилтын үндэс.

Үйлчлүүлэгчдийг мэдэрч, сэтгэл хөдлөлийг дээд цэгт хүргэх, давтан үйлчлүүлэгдчийн тоог нэмэх

Tokyo Petbottle Recycle компани



Өөрсдийн тарьсан хог хаягдлаа өөрсдөө боловсруулж хэрэглэх

Ангилан ялгавал түүхий эд, ялгахгүй бол хог

Toyota Motor Corporation



Just in time

Автоматжуулалт ямар ч Мүда гарах шалтгаан болохгүй

Бүхнийг ил тод байлгах

Эхэлснээ шантарч орхилгүй үргэлжлүүл. Бэрхшээлийн цаана амжилт байдаг.

Хэрэглэгчдийн хүсэл сонирхлыг маш сайн анзаарч харах. Тэндээс шинэ бүтээгдэхүүний болон хөгжүүлэлтийн санаа авах

Өөрсдийн давуу талаа маш сайн ашигла.

Бусдаас суралцаж өөрсдөө мэргэш

Компанийн удирдагч ажилтнуудаа өөрийн үр хүүхэд шигээ бодож хайрла.

Ирээдүйн зорилго зорилтоо ажилчдадаа сайн ойлгуул.

Сул талаа бусдаар нөх (зөвлөх, хамтрах үйлчилгээ)

Sunpac компани



Гогёофүкү компани



Ажлаараа дамжуулан бие биенээ мэдрэх (ажилчид, хамтрагчид, орон нутгийн хүмүүс) Хэрэглэгчдэд бүтээгдэхүүн үйлчилгээг худалдан авах шалтгааныг ойлгуулж мэдрүүл Ажилтан өөрийгөө ойлгох, ирээдүйд хэн байхыгаа тодорхойлох, түүнийхээ төлөө ажиллах нөхцөл боломжоор хангаж чадвал компани тэр хэрээр хөгжинө.

Ricon компани



Асуудал – Арга хэмжээ - Үр дүн Зардлыг багасгасан Эрэмбэлэгдсэн, цэгцлэгдсэн ажиллах таатай орчин Мэдээллийн аюулгүй байдал Үйлчлүүлэгчийн цаана байгаа үйлчлүүлэгчид хүрч үйлчилдэг үнэ цэнийг бий болгох

Коганэя Шокүхин компани



Байнгын үйлчлүүлэгчидтэй байсан учир тэдний төлөө компаниа босгох хэрэгтэй байсан

Худалдан авахуулах биш худалдан авахыг хүсдэг, зорьдог болгох

Үнэ цэнэтэй байснаар хэрэглэгчдийн сэтгэл ханамж өндөр байна.

Бүтээгдэхүүний үнийг хямдруулдаггүй (үнэ цэнийг хадгалах) - Blue ocean стратеги

Ажилчид хүнд биш өөрөө сайхан амьдрахын тулд ажиллаж байгаа гэдгээ ухамсарлах

Дэлхий дахинд бүтээгдэхүүнээ хүргэх биш дэлхийн хаанаас ч зорин ирж наттог амтлан

Dreams popcorn



Инээмсэглэл

Эмх цэгц

Үлгэр дуурайлал, манлайлал

Санхүүгийн шинжилгээг ямагт хийж, дүгнэх, арга хэмжээ авах

Бизнес уулзалтууд



Монгол улсын жижиг дунд бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад гарах боломж олгох

Япон-Монголын өнө эртний найрсаг хамтын ажиллагааг үргэлжлүүлэх

5. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани эсвэл өөрийн бие дээр)



Ашгийн эх үндэс нь эрэмбэ, эмх цэгц, цэвэрлэгээ, цэвэр цэмцгэрт оршино. Үүнийг хэвшүүлж чадвал ямар ч **МУДА** гарахгүй. Нэг Мүда дараагийн Мүда гарах үндэс болдог. Тиймээс **хуурай алчуурыг ч дахин дахин мушгих** хэрэгтэй



Шинэ төслийн хувьд эхнээс нь дуустал хэрэглэх бизнес төлөвлөгөөгөө сайтар боловсруулах

6. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Сургалтаар олж мэдсэн зүйлээ хэрэгжүүлэх оролдлого хийх, сурсан мэдсэнээ өөртөө хадгалах бус бусдадаа хуваалцаж сургалт явуулснаар өөрийн мэдлэг баяжиж, багийн хандлага өөрчлөгдөж үр дүн гарах нь хурдан.

“ДОЛООН БОЛДОГ” ХХК

Нэр: **С.Ганбат**
Албан тушаал: **Гүйцэтгэх захирал**
Үндсэн сургалт төгссөн он: **2018 оны загвар аж ахуйн нэгж**



Компанийн нэр:	Долоон Болдог ХХК
Байгуулагдсан он:	2004
Үйл ажиллагааны чиглэл:	Тавилгын үйлдвэрлэл
Ажилчдын тоо:	210

Компанийн товч танилцуулга

Компаны танилцуулга

- Долоонболдог ХХК 2004 онд байгуулагдсан.
- 2006 онд Евро электроникс ХХК-ийг үүсгэн байгуулж, Hansa, Gorenje, Teка брэндийн цахилгаан барааг импортоор оруулж ирсэн.

genje брэндийн цахилгаан хэрэгслийг албан ёсны эрхтэйгээр борлуулдаг.
- Австрийн Egger, KronoSpan брэндийн E1 зэрэглэлийн хавтан, Blum тоноглол, Италийн Renner брэндийн будаг зэрэг олон улсын чанарын шаардлага хангасан түүхий эд материалаар тавилга үйлдвэрлэж байна.
- 2007 онд Байгалийн чулуун химийн үйлдвэр байгуулсан.
- 2008 онд Kitchen all сүлжээ дэлгүүрээ нээсэн. Одоогоор 5 салбар дэлгүүртэй.
- 2015 онд 10.000 м2 хагас автоматчилсан үйлдвэртэй болсон.





1. Монгол-Японы төвийн Бизнесийн Үндсэн сургалтад суух болсон шалтгаан

1. Японы үйлдвэрүүдтэй танилцах, 5S-г хэрхэн зөв хэрэгжүүлж байгаатай танилцах
2. Компанидаа япон маягийн менежментийг бүрэн хэрэгжүүлэх

2. Бизнесийн үндсэн сургалтад сурсан зүйлээ компанидаа яаж хэрэгжүүлж байна вэ? Компанид гарсан өөрчлөлт

- Эхний ээлжинд 3S –г үйлдвэрийн байрандаа суурилуулах
- Нийт ажилчидтайгаа японы тухай, 3S болон 5S, мөн хувь хүний хүмүүжлийн талаар сургалт зөвлөгөөг өөрийн биеэр орсон.
- 3S-н баг, хамрах хүрээг тодорхой болгосон. Шилдэг кайзэнгийн талаар нийт ажилчдад танилцуулдаг. Энэ нь бусдад санаа өгөх, сэдэлжүүлэх зэрэг ач холбогдолтой болсон.
- Үйлдвэр болон оффисын ажилчдын 3 шаттай цэвэрлэгээний журам батлан хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.
- Үйлдвэрийн байранд бүх ажилчдын оролцоотойгоор аюулгүй байдал нэгдүгээрт гэсэн уриа лоозон хийхээр бэлдэж байна.

5S хэрэгжүүлсний жишээ:

Өмнө	Дараа
	
 <p>Хөх толбо баг өмнө</p>	 <p>Хөх толбо баг дараа</p>

3 шатат цэвэрлэгээний журам
Хэн, хэзээ, хаана, юу хийхийг
тодорхой заасан цэвэрлэгээний
журам нь дээрээ тусгаж өгсөн.
Мөн хүн бүрт цэвэрлэгээний
материал хариуцуулж, нийтээр
ариун цэврийн цагийг үр
ашигтайгаар ашигладаг болохыг
зорьж ажиллаж байна.

ҮЙЛДВЭРИЙН АЖИЛЧДЫН 3 ШАТАТ ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ ЖУРАМ
НЭГ. ЗОРИЛГО

- 1.1 Энэхүү журам нь үйлдвэрийн нийт ажилчдын аюулгүй, эмх цэцгэй, цэвэр орчинд ажиллах нөхцөлийг хангахын тулд нийт ажилчдыг тогтмол цэвэрлэгээг хэвшүүлэхэд оршино.
- ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ, ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ ХУВААРЬ
- 2.1 Долоон Болдог ХХК-н үйлдвэрийн бүх ажилчид хамрагдана.
- 2.2 Үйлдвэрийн ажилчдын ариун цэврийн цагийн хуваарь.

<p>1. ӨДӨР БҮР 5 МИНУТЫН ЦЭВЭРЛЭГЭЭ 17:25-17:30 хуртал</p> <p>Үүнд нь</p> <ol style="list-style-type: none"> 1. Багаж бусад хэрэглэсэн зүйлсээ буцаан байранд нь тавих 2. Хариуцсан тоног төхөөрөмжөө нийтэд нь арчиж цэвэрлэх 3. Хөлөө түрх 4. Шалаа цуурдах 	
<p>2. 1 ХОНОГ БҮРИЙН ХАГАСАЙН ӨДӨР 12:40-13:00 ХҮРТЭЛ</p> <p>Үүнд</p> <ol style="list-style-type: none"> 1. Багаж бусад хэрэглэсэн зүйлсээ буцаан байранд нь тавих 2. Хариуцсан тоног төхөөрөмжөө нийтэд нь арчиж чийгтэй цэвэрлээ хийж 3. Шалаа угаах 4. Тоног төхөөрөмжөө гялалцгал хуурай агуураар арчиж 	

Хувь хүний хөгжлийн төлөвлөгөө

2019 оны эхээр, хүн бүрээр ур чадвар, кайзэн хийх талаар болон өөрийн хувийн зорилгын талаар төлөвлөгөө гаргуулдаг ба дараа нь гүйцэтгэх захирал, хүний нөөцийн алба хамтран хүн нэг бүртэй ганцаарчлан уулзаж ярилцан, санал сэтгэгдлийг нь сонсон, зөвлөгөө өгдөг. Энэ нь ажилчид болон компанийн удирдлага харилцан ойлголцох ач холбогдолтой болсон.

ХУВЬ ХҮНИЙ 2019 ОНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ

ДОЛООН БОЛДОГ ХХК

Алба:

Нэр:

	ОДОО ЯМАР БАЙГАА	2019 ОНД ЯМАР БОЛОХ	ЯАЖ ЗОРИЛГОДОО ХҮРЭХ
Ур чадвар бүтээмжээ нэмэгдүүлэх			
Санаачлага			
Өөрийн хувийн зорилго			

3. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл
Хүний нөөцийг хөгжүүлэх

Бүх зүйлсийн үндэс суурь нь хүн. Мэдлэг, техник, хөрөнгө, эд юмсыг зөвөөр ашиглах нь хүн. Хүн бизнесийг хийдэг. Бүтээгдэхүүнийг хүн хийдэг. Хүн зардаг. Зөв хандлагатай хүн болгон сургаж чадахгүй бол чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж чадахгүй. Менежмент ч сайн явахгүй. Тийм учраас эхлээд хүнээ сургах, зөв хүн болгох хэрэгтэй. Хүний зөвхөн сайн, давуу талыг олж харж, түүнийг нь л ашиглах хэрэгтэй гэж ойлгосон.

3S хөдөлгөөнийг эхлээд хэвшүүлэх, идэвхжүүлэх

Миний хувьд жижиг дунд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг хүмүүст хамгийн эхлээд 3S-с эхлэх нь зөв юм байна гэж харсан. Үүний тулд ажилтан алба бүрд дахин 3S-н сургалтуудын үе шаттайгаар хичээл орж бие биенээсээ суралцах боломжоор ханган ажиллаж байна.

Ажилчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх

Ажилчин сэтгэл хангалуун байж хэрэглэгч сэтгэл хангалуун байна. Ажилтан бүрийн оновчтой саналыг удирдлагын түвшинд авч хэрэгжүүлэх тусам компани улам хөгжин, өсөн дэвжинэ. Ажилчид өөрсдөө бие дааж хийх нь чухал. Харин хийх нөхцөлийг нь бүрдүүлж өгөх хэрэгтэй. Ажиллах орчин эрүүл, аюулгүй байх ёстой. Нөхцөлийг нь бий болгож, бүрдүүлж өгөөд дараа нь авах хэрэгтэй гэсэн үг.

Мүда-г арилгах

Нэг мүда нь өөр нэг мүдаг бий болгож байдаг. Тоёота бол хамгийн муу мүдаг “Юмыг хэтрүүлж үйлдвэрлэх” гэж үздэг. “Их хэмжээгээр үйлдвэрлээд хадгалчихад болно”, “Агуулахдаа их бараатай байхад болно” гэсэн бодол нь эргээд юмыг сайжруулъя гэсэн санааг үндсээр нь үгүй болгодог. Цаг нь тулсан юман дээр их зүтгэл, санаа гарч ирдэг.

4. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

Сургалтын нэгдсэн хөтөлбөр боловсруулан, сургалтууд зохион байгуулж эхэлсэн.

Хүнээ байнга, тасралтгүй сургах хэрэгтэй ба үүний тулд компанийхаа сургалтын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан гаргаж, хэрэгжүүлж эхлээд байна. Сургалтын төлөвлөгөөндөө, зөвхөн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэхээс гадна 3S, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, багаар ажиллах, хувь хүний соёлын талаар сургалт хийхээр оруулсан.

3S-г бүрэн хэрэгжүүлэхээр зохион байгуулалтууд хийж байна.

Нийт ажилчдаа 5, 5 хүнтэйгээр 6 баг болгон хуваасан. Хариуцах хэсэг, хэрэгжүүлэх цаг, хяналт тавих зэргийг тодорхой болгож өгсөн. Өдөр бүр өглөө, орой 5 минут, долоо хоногийн Баасан гарагт 20 минут хийнэ. 3S-н хороо байгуулсан. Хороо нь сар бүр хэрэгжилтийг шалгана. Шалгах хүснэгтийг сайжруулсан ба уг хүснэгтийн дагуу шалгана. Мөн 5S-н самбартай болсон. Хэрэггүй зүйлсийн тавьдаг хэсэг үйлдвэртээ гаргахаар болсон. Багууд хэрэггүй гэсэн зүйлсээ уг хэсэгт дээр тавих ба бусад багт хэрэггүй бол 7 хоногийн дотор хаяна.

5. Сургалтын талаарх сэтгэгдэл, компани хэрэгжүүлж болохуйц жишээ

Сургалт маш өндөр зохион байгуулалттай үр өгөөжтэй болж өнгөрсөн . Японы компаниудын цагийн менежмент болон, ажилчдаа хайрлах арга барилуудаас компани дээрээ системтэйгээр нэвтрүүлэхээр бэлдэж байна.

6. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани эсвэл өөрийн бие дээр)

Хүний нөөцийн албаны 3 болон 5 жилийн төлөвлөгөөг гаргахаар ажиллаж байна.

Мөн хувь хүний амьдралын төлөвлөгөөг гаргахаар эхний ээлжинд албаны дарга нарын төлөвлөгөөг гаргуулахаар бэлдэж байна.

Мөн миний бие хувьдаа хувь хүний хөгжлийн болон хувийн амьдралын төлөвлөгөөг гэр бүлийн гишүүдийн хамтаар гаргаж байна.

7. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Цаг маш сайн барих хэрэгтэй . Та бүхэнд байгаа суралцах боломжтой 14 хоног нь цаашдын амьдралдаа хэрэгжүүлэх нэн чухал хичээл, лекцүүд байгаа тул анхааралтай, идэвхтэй оролцоорой гэж захиж байна. Мөн удирдах түвшний захирлууд өөрийн биеэр явж суралцах нь илүү үр дүнтэй санагдсан.

МУИС-ийн Бизнесийн сургуулийн Бизнес Консалтинг төв

Нэр: **Н.Батсүх**
 Албан тушаал: **Менежер**
 Үндсэн сургалт төгссөн он: **2014**




Компанийн нэр:	МУИС-ийн Бизнесийн сургуулийн Бизнес Консалтинг төв
Байгуулагдсан он:	2005
Үйл ажиллагааны чиглэл:	Төр хувийн хэвшлийн байгууллагуудын ажилчдыг чадавхжуулах, менежментийг сайжруулах сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээ, МУИС-ийн дэлгүүр
Ажилчдын тоо:	4

Компанийн товч танилцуулга

Монгол Улсын Их Сургуулийн Бизнесийн сургууль (хуучнаар Эдийн засгийн сургууль) нь Монгол улсад эдийн засаг, бизнесийн удирдлагын тэргүүлэх мэргэжилтэн бэлтгэх үйлсэд анхдагч байж, улс орныхоо хөгжлийн түүчээ болсон төрийн болон бизнесийн удирдлагын чадварлаг боловсон хүчнийг бэлтгэх үүргээ нэр төртэй биелүүлэн ирсэн ууган сургууль билээ.

"Бизнес Консалтинг Төв" нь МУИС-ийн Бизнесийн сургуулийн харъяанд 2005 оны 11-р сарын 28-наас үйл ажиллагаагаа явуулж байгаа ба тус төвийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь өмчийн хэвшил харгалзахгүйгээр бүхий л хэвшлийн байгууллагуудтай харилцан үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэн өргөжүүлэхэд чиглэгдэж ирсэн. 2017 оноос МУИС-ийн лого бүхий бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, багш, судлаачид, оюутнуудын инновацид суурилсан бүтээгдэхүүний эдийн засгийн эргэлтэнд оруулахад хувь нэмэр оруулах, оюутнуудыг дадлагажуулах зорилгоор МУИС-ийн дэлгүүрийг хариуцан ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэл:



**Бизнесийн
байгууллага,
төр, олон
нийтийн
байгууллагуудын
хүний нөөцийг
хөгжүүлэх
сургалт**



1. Байгууллагын удирдлага, ажилчдыг чадавхжуулах богино хугацааны сургалт
 - ✓ Бизнесийн удирдлагын дээд курс (Ахисан түвшний менежментийн сургалт)
 - ✓ Баг бүрдүүлэлт, манлайлал
 - ✓ Бизнесийн харилцаа, цагийн менежмент, стресс менежмент
 - ✓ Санхүү, хөрөнгө оруулалтын менежмент
 - ✓ Бизнес аналитикс
 - ✓ Эдийн засгийн хэлэлцээр ба гаалийн тарифын хөнгөлөлт
 - ✓ Компанийн эрсдэлийн удирдлага, дотоод хяналт ба дотоод аудит
 - ✓ Загварчлах сэтгэлгээ (Design Thinking)
 - ✓ Компанийн засаглалын сургалт (ТУЗ-д орж ажиллах эрх бүхий сертификат олгох)
2. Энтрепренершипийн чиглэлээрх сургалт
 - ✓ NUM Startup 1.0 сургалт (Гарааны бизнес эрхлэх сонирхолтой, гарааны бизнес эрхлэж буй хүмүүст зориулсан сургалт)
3. Тендер шалгаруулалттай холбоотой сургалт
 - ✓ ХАА-н мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалт (Үнэлгээний хороонд орж ажиллах эрх бүхий сертификат олгох)
 - ✓ Тендерт амжилттай оролцох нь (Улсын тендерт оролцох сонирхолтой, оролцдог компаниудад зориулсан сургалт)
4. Байгууллагын захиалгат сургалтууд
(стратеги, хүний нөөц, манлайлал, маркетинг, инноваци, санхүү, харилцааны ур чадвар, нягтлан бодох бүртгэл гэх мэт)
5. Менежер манлайлагчдыг хөгжүүлэх хөтөлбөр

1. Монгол-Японы төвийн Бизнесийн Үндсэн сургалтад суух болсон шалтгаан

1. Төвийн менежментийн үйл ажиллагааг сайжруулах
2. Өөрийгөө хөгжүүлэх, шинэ мэдлэг олж авах

**2. Бизнесийн үндсэн сургалтад сурсан зүйлээ компанидаа яаж хэрэгжүүлж байна вэ?
Компанид гарсан өөрчлөлт**

1. Төвийн үйл ажиллагаанд 3S хэрэгжүүлж байна
2. Дэлгүүрийн барааны өрөлт, дэлгүүрийн менежментийг сайжруулан ажиллаж байна.

3. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл

Захирлын манлайлал

Ажилчдаа ямар байлгахыг хүсэж байна өөрөө яг түүн шиг байх хэрэгтэй. Япон компаниудын захирлууд ажилчдаа үлгэр дууриал үзүүлж, манлайлж байна.

Хамтын ажиллагаа

Өөрсдийн давуу болон сул тал, хэвийн байдлаа багаараа тодорхойлж, одоогийн түвшин болон хэвийн байдлын хоорондох зөрүүг тодорхойлж, зөрүүг арилгах боломжуудыг гаргах шаардлагатай байна. Өөрсдийн сул тал, зөрүүтэй байдлыг арилгах нэг арга нь бусад хувь хүн, байгууллагуудтай хамтран ажиллах юм. Бид ихэнхдээ бүгдийг хийж чадна хэмээн үздэг нь хүчийг хэт тарамдуулж байгааг олж харсан.

Хэрэглэгчтэйгээ ойр байх нь

Бид өрсөлдөөний давуу байдлаа одоогийн нөөц бололцоо, техник технологи, ноу-хау, хүний нөөц гэх мэт зүйлд тулгуурлан тодорхойлдог. Гэхдээ өрсөлдөөний давуу талыг бий болгоход хэрэглэгчтэй ойр байж, тэдний эрэлт хэрэгцээг судлах хэрэгтэйг тэр болгон анзаараад байдаггүй. Бид тодорхой хэрэглэгчийн хэрэгцээ, асуудлыг шийдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг тэдэнд хүргэж, түүнээсээ буцаагаад ашиг хүртдэг. Хэрэглэгчийн хэрэгцээ, асуудлыг тэдэнтэй ойр байж олж авна.

Ажилчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх

Ажилчин ажилдаа сэтгэл хангалуун бус үед яг тийм сэтгэлээр хэрэглэгчтэй харилцдаг байна. Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхийн тулд ажилчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл Ажилчдын сэтгэл ханамж=Хэрэглэгчийн сэтгэл ханамж юм. Тиймээс удирдах албан тушаалтан бүр ажилчдын амьдрал, тэдний юу хүсэж эрмэлздэг талаар ойр ойрхон уулзаж, ярилцдаг байна. Ярилцлагын үр дүнд олж авсан мэдээлэлдээ үндэслэн ажилчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх үйл ажиллагаануудыг зохион байгуулдаг.

5S Хэрэгжүүлэх

Зөвхөн захирал өөрийн бодож байгаагаар 5S хэрэгжүүлэх гэж оролдох нь өрөөсгөл юм. Эцсийн дүндээ 5S хэрэгжүүлэх хүмүүс нь захирал биш ажилчид байдаг. Тиймээс ажилчдыг идэвхитэй оролцуулж, тэднээр кайзэн санаа гаргуулж, багаараа хамтран ажиллах нь зүйтэй. Захирлын зүгээс үлгэр дууриал үзүүлэх хэрэгтэй.

4. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

Суралцсан зүйлсээ бусадтайгаа хуваалцах

Суралцсан зүйлсээ хэрэгжүүлэхийн тулд бусадтайгаа мэдээллээ солилцож, хамтдаа нэг зүгт харахыг хичээж байна. Хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажлуудаа бусдадаа танилцуулж, хүлээн зөвшөөрүүлж, хамтдаа хэрэгжүүлэх шийдвэр гаргасан. Цаашид үйл ажиллагаагаа сайжруулах зорилгоор сурсан зүйлсээ алхам алхмаар/бага багаар хэрэгжүүлэх болно.

5. Сургалтын талаарх сэтгэгдэл, компанид хэрэгжүүлж болохуйц жишээ

Сургалт маш их үр өгөөжтэй, үр дүнтэй болсон. Бид 14 хоногийн хугацаанд 14 компанийн үйл ажиллагаатай танилцаж, 2 удаагийн бизнес уулзалтад оролцож, 2 удаагийн танхимын сургалтыг авсан. Тулгамдаж байсан зарим асуудлуудаа шийдвэрлэх арга замыг олж авсан.

6. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани эсвэл өөрийн бие дээр)

- Шинээр орсон ажилтнуудад зориулсан гарын авлага, сургалтын агуулгыг боловсруулах
- Бүтээгдэхүүний шинэ санаа авах, түүнийг үнэлэх аргачлалыг боловсруулах
- Ажилтнуудыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулах

7. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Сургалтаар суралцсан зүйлээ хамтран ажиллаж буй ажилчиддаа ойлгуулсаны үндсэн дээр хамтдаа хэрэгжүүлэх хэрэгтэй. Хэрэгжүүлэх явцад ямар хүндрэлүүд гарч болох талаар урьдчилан бодож, түүний эсрэг авах арга хэмжээ, сэтгэл зүйгээ бэлдээрэй. Урт хугацаандаа үр өгөөжөө өгнө гэдэгт итгээд бүү шантраарай.

“МОНОС ФАРМ” ХХК

Нэр: **Б.Энхзаяа**

Албан тушаал: **Үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал**

Үндсэн сургалт төгссөн он: **2018**



<p>Компанийн нэр:</p>	<p>Монос фарм ХХК</p>																																																		
<p>Байгуулагдсан он, үйл ажиллагааны чиглэл:</p>	<p>1990 онд байгуулагдсан монголын хувийн хэвшлийн эм үйлдвэрлэгчдийн анхдагч бөгөөд үйлдвэрлэл, эрдэм шинжилгээ судалгааны чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж буй эм хангамжийн салбарын тэргүүлэгч үйлдвэрүүдийн нэг билээ.</p> <p>100 гаруй нэр төрлийн эм бэлдмэл үйлдвэрлэлдгээс 20 орчим нэр төрлийн эмийг цоо шинээр брэнджүүлэн бүтээж, импортын 80 гаруй бэлдмэлийн монгол улсын үндэсний болон үйлдвэрлэгчийн фармакопейн өгүүлэл, технологийн зааврыг шинээр боловсруулан үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байна. Мөн түүнчлэн Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон эм бэлдмэлээс 20 орчим нэр төрлийг үйлдвэрлэн МУ-ын хүн амын эрүүл мэндийг хамгаалах үйлсэд гар бие оролцож ирсэн хамт олон болно.</p> <p style="text-align: center;">ОЛОН УЛСЫН GMP СТАНДАРТАД НИЙЦСЭН</p>																																																		
<p>Ажилчдын тоо:</p> <p style="text-align: center;">172</p>	<div style="display: flex; justify-content: space-between;"> <div style="width: 45%;"> <div style="border: 1px solid gray; padding: 5px; margin-bottom: 5px;">Боловсрол эзэмшсэн байдал</div> <table border="1" style="width: 100%; text-align: center;"> <tr> <td style="width: 50%;">Монголд</td> <td style="width: 50%;">Гадаадад</td> </tr> <tr> <td style="font-size: 24px;">96%</td> <td style="font-size: 24px;">4%</td> </tr> </table> <div style="border: 1px solid gray; padding: 5px; margin-bottom: 5px;">Ажилтнуудын хүйсийн байдал</div> <table border="1" style="width: 100%; text-align: center;"> <tr> <td style="width: 50%;">Эрэгтэй</td> <td style="width: 50%;">Эмэгтэй</td> </tr> <tr> <td style="font-size: 24px;">30%</td> <td style="font-size: 24px;">70%</td> </tr> </table> </div> <div style="width: 45%;"> <p>Эм судлалын хүрээлэн</p> <p>Үйлдвэрлэл 3 хэсэг</p> <p>БХ, Чанарын хяналтын алба</p> <p>Инженер техникийн алба</p> <p>Чанарын баталгаажилтын алба</p> <p>Маркетинг борлуулалтын газар</p> <p>Санхүүгийн газар</p> <p>Захиргаа Хүний Нөөцийн Алба</p> </div> </div> <div style="margin-top: 20px;"> <p style="text-align: center;">Нийт ажилтнуудын нас</p> <p style="text-align: center;">Дундаж нас: 31.2 нас</p> <table border="1" style="width: 100%; text-align: center;"> <thead> <tr> <th>Generation</th> <th>TOO</th> <th>ХУВЬ</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Silent generation (1920-1945)</td> <td>1</td> <td>0.6%</td> </tr> <tr> <td>Baby boom generation (1946-1965)</td> <td>1</td> <td>0.6%</td> </tr> <tr> <td>Generation X (1966-1980)</td> <td>38</td> <td>21.7%</td> </tr> <tr> <td>Generation Y (1981-1999)</td> <td>135</td> <td>77.1%</td> </tr> <tr> <td>Generation Z (2000-2018)</td> <td>0</td> <td>0%</td> </tr> </tbody> </table> </div> <div style="margin-top: 20px;"> <p style="text-align: center;">Ажилласан жилийн дундаж</p> <p style="text-align: center;">Дундаж жил: 3.9 жил</p> <table border="1" style="width: 100%; text-align: center;"> <thead> <tr> <th>Хугацаа</th> <th>TOO</th> <th>ХУВЬ</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>3-хүртэлх жил (1-12 сар)</td> <td>53</td> <td>30%</td> </tr> <tr> <td>1-3 жил (13-25 сар)</td> <td>51</td> <td>29%</td> </tr> <tr> <td>3-5 жил (26-39 сар)</td> <td>20</td> <td>11%</td> </tr> <tr> <td>5-8 жил (40-52 сар)</td> <td>20</td> <td>11%</td> </tr> <tr> <td>8-11 жил (53-65 сар)</td> <td>15</td> <td>9%</td> </tr> <tr> <td>11-16 жил (66-81 сар)</td> <td>10</td> <td>6%</td> </tr> <tr> <td>16-аас дээш жил (82-100 сар)</td> <td>6</td> <td>4%</td> </tr> </tbody> </table> </div>	Монголд	Гадаадад	96%	4%	Эрэгтэй	Эмэгтэй	30%	70%	Generation	TOO	ХУВЬ	Silent generation (1920-1945)	1	0.6%	Baby boom generation (1946-1965)	1	0.6%	Generation X (1966-1980)	38	21.7%	Generation Y (1981-1999)	135	77.1%	Generation Z (2000-2018)	0	0%	Хугацаа	TOO	ХУВЬ	3-хүртэлх жил (1-12 сар)	53	30%	1-3 жил (13-25 сар)	51	29%	3-5 жил (26-39 сар)	20	11%	5-8 жил (40-52 сар)	20	11%	8-11 жил (53-65 сар)	15	9%	11-16 жил (66-81 сар)	10	6%	16-аас дээш жил (82-100 сар)	6	4%
Монголд	Гадаадад																																																		
96%	4%																																																		
Эрэгтэй	Эмэгтэй																																																		
30%	70%																																																		
Generation	TOO	ХУВЬ																																																	
Silent generation (1920-1945)	1	0.6%																																																	
Baby boom generation (1946-1965)	1	0.6%																																																	
Generation X (1966-1980)	38	21.7%																																																	
Generation Y (1981-1999)	135	77.1%																																																	
Generation Z (2000-2018)	0	0%																																																	
Хугацаа	TOO	ХУВЬ																																																	
3-хүртэлх жил (1-12 сар)	53	30%																																																	
1-3 жил (13-25 сар)	51	29%																																																	
3-5 жил (26-39 сар)	20	11%																																																	
5-8 жил (40-52 сар)	20	11%																																																	
8-11 жил (53-65 сар)	15	9%																																																	
11-16 жил (66-81 сар)	10	6%																																																	
16-аас дээш жил (82-100 сар)	6	4%																																																	



АЛСЫН ХАРАА

Монгол оюун санааг дэлхийд таниулна

ЭРХЭМ ЗОРИЛГО

Хүмүүний эрүүл мэндийг тэтгэх эмчилгээний өндөр идэвхт эм түүний чанараар эмзүйн салбартаа тэргүүлэгч, инновацын хөгжлийг дээдэлсэн байгууллага байна

ҮНЭТ ЗҮЙЛС

- Хамт олон
- Хэрэглэгч
- Чанар
- Мэдлэг чадвар, оюуны нөөц
- Харилцагч

“Монос фарм” ХХК нь 1996 онд дэргэдээ эм судлал, эрдэм шинжилгээний төвийг байгуулсан нь өнөөдөр Эм Судлалын Хүрээлэн болон өргөжиж 30 орчим ажилтан ажиллаж байгаагийн дотор Төрийн шагналт 1, Академич 4, Биологийн ухааны доктор, Мал эмнэлэгийн ухааны доктор, Эм зүйн ухааны доктор, Докторант, Биологийн ухааны магистр, Эм зүйн ухааны магистр, Эм зүй, Биологийн ухааны магистрант тус тус ажиллаж байна. Тус хүрээлэнгийн бүтээл болох Дархлаа сэргээх Салимон, шүдний тулгуур эд, буйл, амны салстын үрэвсэл намдаах, эмчлэх Дентамон бэлдмэл нь Монгол Улсын төрийн шагнал хүртсэн бүтээл болсон билээ.

Үүнээс гадна тус хүрээлэн нь өөрийн болон бусад мэргэжлийн байгууллагын нийт 19 эрдэмтэн, судлаачаас бүрдсэн эрдмийн зөвлөлтөй бөгөөд уг эрдмийн зөвлөлөөр судалгааны ажлыг хэлэлцэхээс гадна “Монос Эм зүйн шинжлэх ухааны их сургууль”-ийн “Эм зүйн ухааны Магистр”, “Эм зүйн ухааны Доктор”-ын зэрэг олгох үйл ажиллагаа явуулж байна.

Зураг. Эм судлалын хүрээлэнгийн судалгааны чиглэл


Эм судлалын хүрээлэн



2014 он хүртэл үйл ажиллагаагаа явуулж байсан үйлдвэрлэлийн байр нь 1957 онд

ашиглалтанд орсон эмнэлэг, оффисын зориулалтаар баригдсан байшин ба манай компани 1994 оноос уг байранд үйл ажиллагаа явуулж эхэлсэн. 2000 онд үйлдвэрлэлийн зориулалттай болгон зассан ба 2002 онд хувьчилж авсан. Уг барилга нь зориулалтын агааржуулалтын системгүй, өрөө

1. Монгол-Японы төвийн Бизнесийн үндсэн сургалтад суух болсон шалтгаан




2. Бизнесийн үндсэн сургалтад сурсан зүйлээ компанидаа яаж хэрэгжүүлж байна вэ?


2.1 БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ БУУРУУЛАХИГОЛОГДОЛ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн явцад үүсэж буй гологдол бүтээгдэхүүнийг 2017-2018 оны байдлаар бүртгэлжүүлэхэд нийт үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнд 4-5% хорогдол гарч буйг тогтоосон. Энэхүү үүсэж буй гологдлыг 2019 онд 30-50% бууруулах боломж байгааг судалгаагаар илрүүлж, гологдол бүтээгдэхүүнийг бууруулахад дараах арга хэмжээг авч ажиллаж байна.

- Гологдол ихээр үүсгэж буй үйлдвэрийн шугамыг илрүүлж, шинээр орон тооны шалгагч ажилтан томилж ажилуулах
- Гологдол бүтээгдэхүүнийг ангилан ялгах, аюулгүй байдлаар устгалд оруулах талаар эмийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллах зааварчилгааг боловсруулан, мөрдөж ажиллах
- Үйлдвэрлэлийн сар бүрийн мэдээнд гологдлын тайланг гаргаж хэвших, тайлан мэдээг гаргаж буй ажиллагсдад мэдээллийг нээлттэйгээр зарлах



2.2 ҮЙЛДВЭРИЙН УДИРДЛАГЫН СИСТЕМИЙГ ӨӨРЧЛӨХ



2014-2018 оныг хүртэл үйлдвэрлэлийг Үйлдвэрийн менежерийн удирдлага дор 5 цехийн системээр 3 мастер шалгагч үйл ажиллагааг удирдан ажилладаг байсан. Энэ үед үйлдвэрийн менежер удирдлагын баг болон бусад алба нэгжтэй харилцаж үйлдвэрийн нөхцөл байдлыг танилцуулж, үйлдвэрийн дотоод зохион байгуулалтын ажиллагааг 3 мастер шалгагчид хариуцуулан ажилладаг байсан. Ингэснээр үйлдвэрийн менежер үйлдвэрт тулгарч буй бодит асуудалд биечлэн оролцох боломж бүрддэггүй байсан ба гаргаж буй шийдвэр, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ бодит бус байна гэж үзсэн. 2018 оны 3 сараас ХАТУУ ТУГНАГДСАН ЭМИЙН ҮЙЛДВЭР, ГАЛЕНЫ БЭЛДМЭЛИЙН ҮЙЛДВЭР, ШМҮТ ҮЙЛДВЭР гэсэн 3 үйлдвэрт ангилан үйлдвэр тус бүрдээ 1 хариуцсан үйлдвэрийн менежертэй болсон. Ингэснээр үйлдвэрийн менежерүүд бодит нөхцөл байдал, төлөвлөлтийн хоорондын зөрүү, үйл ажиллагааны гүнд илүү ойртож ажиллаж эхэлсэн ба 3 ГЕН зарчмаар ажиллаж эхэлсэн гэж үзэж байна.

2.3 ҮЙЛДВЭРЛЭЛИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР ТАСРАЛТГҮЙ СУРАХ

Эмийн үйлдвэрийн хувьд гол дамжлага дээр ажиллах түлхүүр хүн хүчнийг 2-3 жил ажилласан ажлын туршлага бүхий ЭМ ЗҮЙЧ мэргэжилтэн байх ёстой гэсэн шаардлага MNS 5524:2016 “Эм үйлдвэрлэлд тавигдах ерөнхий шаардлага” стандартаар шаарддаг. Тэгтэл өнөөгийн Эм зүйч бэлтгэж буй сургуулиудын сургалтын программд үйлдвэрлэлийн удирдлагын талаар ямар нэг мэдлэг олгох сургалт өдий хүртэл байхгүй байна. Тиймээс 2018 оноос эхлэн МЯТ-ийн Үйлдвэрлэлийн удирдлага сургалтад менежерүүдээ хамруулж эхэлсэн. 2019 оны сургалтын төлөвлөгөөнд мөн 1-2 менежер сургахаар төлөвлөөд байгаа төдийгүй дотоод сургалтын төлөвлөгөөндөө энэ чиглэлийн дотоодын болон гадаадын сургагч багштай хамтран ажиллахаар төлөвлөөд байна.




2.4 БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОЛОН ТҮҮНИЙ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТИЙГ БҮРТГЭХ НЭГДСЭН СИСТЕМТЭЙ БОЛОХ

Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өдөр тутмын үйл явцын бүртгэлүүдийг ихэвчлэн дэвтэрт бүртгэлжүүлэх, баримтжуулах тогтолцоотой байсан. Эдгээр баримтжуулалт дахин ашиглагдах, өгөгдөлд дүн шинжилгээ хийх, асуудлын мөрөөр арга хэмжээ авах зэрэг ажиллагаа дутагдалтай байсан тул хэрхэн программд оруулах талаар судалгааг хийж эхэлсэн. Ингэснээр өдөр тутмын бүртгэлүүдийг excel file- аар үүсгэж эхэлсэн ба хариуцсан ажиллагсдыг дундын share file-д холбож өгсөн. Энэ үйл ажиллагаа нь мэдээллийг цаг алдалгүй, үнэн зөв авахад ашигтай байгаа ба өгөгдөлд дүн шинжилгээ хийхэд хялбар болж өгсөн.



3. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл



1. ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ УДИРДАХ ЯПОН МЕНЕЖМЕНТ

Японы үйлдвэрүүд өөр өөрийн аргачлал, дадал, уламжлалаар үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа удирдан явуулж байгаа боловч бүгд доор дурьдсан аргачлалуудыг үйлдвэртээ ягштал мөрдөж ажиллаж байгаа нь дадлагын явцад ажиглагдаж байсан. Мөн эдгээр арга аргачлал нь япон хүний амьдралын хэмнэл,

хүүхэд хүмүүжлийн гол хэрэглүүр болсон мэт сэтгэгдэл төрсөн билээ.

Дадлага сургалтын явцад 3S\5S, KAIZEN, 3 GEN, 7 MUDA, JUST IN TIME, CANBAN LIST, JIDOKA, VALUE STREAM MAP, RISK ASSESSMENT зэрэг олон аргачлалыг хэрхэн нэвтрүүлсэн талаар бодит байдалд танилцлаа.



2. АВТОМАТЖУУЛАЛТ

Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах, чанартай бүтээгдэхүүнийг хэрэглэгчид хүргэх, өртөг багатай, ашигтай бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд туслах нэг чухал хэрэгсэл бол үйлдвэрийн автоматжуулалт юм.

- ✚ DIGITAL BRING SYSTEM
- ✚ JIDOKA
- ✚ ANDON BOARD
- ✚ ERP

3. ХҮНДЭТГЭХ, ХАЙРЛАХ УХААН

Хайрлагдан, хүндлэгдсэн ажилтантай компанийн хэрэглэгч аз жаргалтайгаар бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авалт хийдэг гэнэ.

ХҮНИЙ ТУЙЛЫН АЗ ЖАРГАЛ ЮУ ВЭ?

- Хайрлуулах
- Магтуулах
- Туслах
- Хэрэгтэй гэдгээ мэдрэх



4. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

- ✚ 2017 оны 9 сараас 2018 оны 4-р сар хүртэлх хугацаанд Бизнесийн үндсэн сургалтад хамрагдан бизнесийн удирдлагын онолын талаарх ерөнхий мэдлэгээ бататган Япон орныг зорьж, сургалтаар олж авсан мэдлэг бодит байдалд хэрхэн хэрэгжсэн талаар нүдээр үзсэн нь хэрхэн хийх арга замыг зааж өгсөн үр дүнтэй, өгөөжтэй сургалт боллоо.
- ✚ Мөн ЖАЙКА-ийн аливаа зүйлийг зохион байгуулж буй байдал, хариуцлагатай байдал, цаг баримтлах, дүрэм журмыг мөрдөж буй зэрэг нь монголчууд бидэнд сурах зүйл, хийх зүйл маш их байгааг сануулсан аялал болсон.
- ✚ Дашрамд дурьдахад биднийг хариуцаж ажиллаж байсан багш нар хариуцлагатай, мэдлэг чадвартай, эерэг зөв хандлагатай үлгэр жишээ хүмүүс байсан ба Х.Гармаабазар болон орчуулагч багш Тошиюки Учида нартаа маш ихээр талархаж байна.


Онцлох зүйл: Минагава Кэнтаро профессорын КАЙЗЭН ХИЙХЭД АНХААРАХ ЗҮЙЛС сэдэвт хичээл нь бидэнд үнэхээр их хэрэгцээтэй хичээл байлаа. Бид 14 хоногийн турш 10 гаруй компанийн үйл ажиллагаатай танилцсан ба эдгээр үйлдвэрийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн арга, хэрэгслүүдийг ХЭРХЭН ӨӨРИЙН КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛЭХ гэдгийг үзүүлсэн үр, өгөөжтэй дадлага сургалт байсан. Цаашид үйлдвэрлэлтэй танилцах болон үйлдвэрлэлийн менежментийн аргачлалуудыг бодит байдалд хэрхэн нэвтрүүлж болох талаар workshop-той дадлага сургалтыг хослуулан явуулбал үр дүн илүү сайжирна гэж найдаж байна.

5. Сургалтын талаарх сэтгэгдэл, компанид хэрэгжүүлж болохуйц жишээ

1. ЯМАОКА СЭЙСАКУШО ХК

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ХЭРЭГЦЭЭ

Хүний нөөцийн хөгжил, чадваржуулах, ур чадварын үнэлгээ, сургалтын хэрэгцээ зэргийг "Ур чадварын менежментийн пирамид" (MOS) ашиглан тасралтгүйгээр хөгжүүлсэн жишээг групп компаниараа хөгжүүлэх шаардлагатай байна гэж үзсэн. Энэ компанийн УР ЧАДВАР НЬ МЕНЕЖМЕНТИЙН ГОЛ ҮНДЭС УЧРААС ТЕХНИКЧДИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ ЗАМААР НЭМҮҮ ӨРТГИЙГ УЛАМ НЭМНЭ ГЭЖ ҮЗДЭГ үзэл нь манай салбарын баримтлалтай их дөхүү санагдсан.



2. ТАНАКА ТЕК



3S гэж зөвхөн эрэмбэлэх, цэгцлэх, цэвэрлэх талаар яригддаг зүйл биш 3S-ыг хэрэгжүүлэх нь "Аливааг зөв бодож, ойлгох аргыг үргэлж эрж хайж, эзэмших" мөн чанарыг ойлгох гэж үздэг энэ компани болон бусад японы компаниудын амжилтын үндэс нь 3S\5S юм. Монголын бүх компаниуд энэ хөдөлгөөнийг хэвшүүлэн ажиллах шаардлагатай байна. Өдөр тутмын үйлдвэрлэлийн төлөвлөлтийн самбар, түүний хөтлөлт, ахуйн зориулалтын жижиг хэрэгслийн захиалгын шүүгээ, just in time - өдрийн ажлыг өдөрт нь дуусгах хянах самбар зэрэг самбаруудыг

компани дээрээ хэрэгжүүлнэ.


3. ХАГҮРҮМА ХК буюу НИСДЭГ МАШИН

Олон улсын дизайн хөгжүүлэлтийн агентуудтай гэрээгээр ажилладаг энэ компани тухайн компанидаа шинэ бүтээгдэхүүний дизайн захиалгаар өгч, гэрээний дагуу төрөл бүрийн загварууд хүлээн аваад бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн багаараа тухайн гаргах гэж буй брэндийн онцлогт тохирсон загвар сонгож шинэ бүтээгдэхүүн гаргадаг юм байна. Энэ аргыг нэвтрүүлбэл сайн дизайнтай бүтээгдэхүүн гарган авах боломж бүрэлдэнэ гэж үзлээ.

4. SUNPAC

ODM буюу бүтээгдэхүүн хөгжүүлэлт:
Сар бүр 100 шинэ санаа, хуучин бүтээгдэхүүнийг сайжруулах санал ажиллагсадаасаа хүлээн авч мөн өмнөх үйлдвэрлэлийн биг датанд дүн шинжилгээ хийж өөрт хэрэгтэй мэдээллийг түүн авч, дүн

шинжилгээ хийж, шүүн тунгааж дараагийн санаагаа ургуулан гаргаж ажилладаг энэ багийн бизнес моделийг нэвтрүүлбэл их өгөөжтэй байхаар санагдлаа. Шинэ санаануудаа экселийн файлд боловсруулан, дүн шинжилгээ хийдэг.



6. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани эсвэл өөрийн бие дээр)

1. СУРГАЛТ ХӨГЖИЛ

1.1 Байгууллагын дотоод болон гадаад сургалтын төлөвлөгөөнд ҮЙЛДВЭРЛЭЛИЙН УДИРДЛАГА-ын талаарх сургалтыг мэргэжлийн байгууллагаас тасралтгүй авах байдлаар тусгах, мөн туршлагатай мэргэжилтэнг (гадаад болон дотоод) өөрийн компани дээр зөвлөх үйлчилгээ авах байдлаар хамтран ажиллах

1.2 Монос группын үйлдвэрлэлийн бусад компаниудад үйлдвэрлэлийн менежментийг хэрхэн сайжруулах талаар АМЖИЛТЫН ГАРЦ хөтөлбөрөөр дамжуулан сургалт, ухуулга хийж, МЯТ болон бусад холбогдох мэргэжилтнүүдтэй холбоо тогтоох боломжийг зааж өгөх

2. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН МЕНЕЖМЕНТ САЙЖРУУЛАХ

1.3 Өөрийн компани дээр тулгараад байгаа асуудлыг хэрхэн илрүүлэх, асуудлыг шийдвэрлэх аргачлалд ахлах болон дунд шатны менежерүүдийг сургах зорилгоор энэ чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэнтэй хамтран ажиллах, улирал тутамд 1 асуудлаар workshop хийж, үр дүнг үнэлж ажиллах

1.4 2019 оны ЗААН-ийг хөгжүүлэх хөтөлбөрт хамрагдах, үүний тулд ахлах болон дунд шатны мэргэжилтнүүдийг МЯТ-ийн төлөвлөгөөт сургалтад хамруулах

3. ӨРТӨГ БУУРУУЛАХ

3.1 Үйлдвэрлэлийн ажиллагсдын бүтээмжийг хэмжих, сайжруулах аян өрнүүлэх, бүтээмжийн самбар ажиллуулах

3.2 Гологдол бүтээгдэхүүнийг хэмжих ажиллагааг үргэлжүүлэх, гологдол бууруулах арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлэх

4. ӨӨРИЙГӨӨ ХӨГЖҮҮЛЭХ

4.1 Өдөр тутмын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийхэд мэдээллийг цуглуулж уншиж чаддаг байхын тулд Data analyst болон excel master байх шаардлагатай ба энэ чиглэлээр сургуульд сурах

4.2 Япон, Солонгос зэрэг орнуудад ажилтан солилцооны хөтөлбөрт хамрагдаж адил төстэй үйлдвэрийн компанид богино хугацаагаар ажиллах талаар судлах, боломж олдвол хамтран ажиллаж, сайн туршлагыг нэвтрүүлэх ажлыг тасралтгүй гүйцэтгэх

4.3 Монгол улсад хог хаягдал боловсруулалт, цуглуулах ажиллагаа дутмаг байгаа тул өөрийнхөө хэмжээнд байгууллага дээрээ, гэр бүлийн хүрээнд, сургуулиудад хог хаягдал болон дахивар бүтээгдэхүүнийг ангилан, ялгах, цуглуулах зэрэг сургах, сурталчлах ажилд тууштай ажиллана.

7. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

- ✚ Үйлдвэрлэлийн удирдлага сайжруулах арга хэрэгслүүд нь тууштай байх, уйгагүй байхыг маш их шаарддаг тул сэтгэлийн хөөрлөөр бус сайтар төлөвлөж аливаа ажлыг эхлэх
- ✚ Хамтран ажиллах удирдлагын багийг тасралтгүй сургалтаар хангах, мэргэжлийн эрх бүхий мэргэжилтнээс зөвлөх үйлчилгээ авах
- ✚ Үйлдвэрлэлийн удирдлагыг нэвтрүүлсэн тэргүүн туршлага бүхий адил төстэй үйл ажиллагаа явуулдаг компаниудаар хамтран ажиллагсадтайгаа уулзалт хийх, тэднийг сэдэлжүүлэх
- ✚ Өөрийгөө байнга сэдэлжүүлэх арга хэрэгсэл олох/сургалтаар эсвэл ямар нэг холбоонд нэгдэх эсвэл өөрөө сургагч багш байх зэрэг.

“СОПОКО” ХХК

Нэр: **С.Манлай**
Албан тушаал: **Гүйцэтгэх захирал**
Үндсэн сургалт төгссөн он: **2018**



Компанийн нэр:	Сопоко ХХК
Байгуулагдсан он:	2011
Үйл ажиллагааны чиглэл:	Сэргээгдэх эрчим хүчний станцын угсралт, суурилуулалт, нарны цахилгаан үүсгүүрийн үйлдвэрлэл, худалдаа
Ажилчдын тоо:	13

Компанийн товч танилцуулга

2011 онд ЖАЙКА-ийн 2 шатлалт зээлийн санхүүжилтээр байгуулагдаж, 2012 оноос нарны цахилгаан үүсгүүр үйлдвэрлэж эхэлсэн. Монголд нарны цахилгаан үүсгүүр үйлдвэрлэж байгаа цор ганц компани юм. Бид жил ирэх тусам нарны цахилгаан үүсгүүрийнхээ чанар болон үзүүлэлтийг сайжруулсаар байна. 2016 оноос 2 талаасаа нарны эрчимийг шингээдэг bifacial нарны цахилгаан үүсгүүрийг үйлдвэрлэж эхэлсэн. 2018 оноос 2 талдаа шилтэй double glazing нарны цахилгаан үүсгүүрийг үйлдвэрлэж байна.

Хүний нөөц: Манай компани нийт 13 ажилтантай. Үүнээс инженер техникийн 6 ажилтантай.

Үйл ажиллагаа:

2012 оноос нэг талт НЦҮ үйлдвэрлэж эхэлсэн.

2013 оноос бараа бүтээгдэхүүний туршилт, зах зээлийн судалгааны ажил хийж эхэлсэн.

2014 оноос тогтмол хүчдэлийн цахилгаан бараа болон малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх бүтээгдэхүүнүүдийг худалдаанд гаргасан.

2015 оноос мотоциклийн худалдаа нэмэлтээр бий болгосон. Үүрэн телефоны компаниудтай хамтран ажиллаж орон нутагт дахин дамжуулах станцуудыг НЦҮ-ээр хангаж эхэлсэн.

2016 оноос bifacial НЦҮ үйлдвэрлэж худалдаанд гаргасан.

2017 оноос угсралт суурилуулалт хийх судалгааг хийж эхэлсэн.

2018 оноос шинэ загварын мотоцикл болон 2 талдаа шилтэй double glazing НЦҮ үйлдвэрлэж худалдаанд гаргасан. НЦҮ-ийн станцын угсралт, суурилуулалт хийж эхэлсэн.

Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн хувьд:

1. Стрингер - Энэхүү төхөөрөмж нь селлний бичил цууралтыг шалгаад, нарийн туузыг тасдаад, хагаралгүй селлнүүдийг компютераас өгсөн тоогоор цуваа болгож гагнах зориулалттай. Харин бичил цууралт үүссэн селлнүүдийг ялгаж ангилна.



Техникийн үзүүлэлт

№		Үзүүлэлт
1.	Загварын нэр	B210D
2.	Серийн дугаар	1103321D
3.	Чадал	16кВт
4.	Ажиллах хүчдэл	380В
5.	Хийн даралт	0,6Па
6.	Хэмжээ	5500x1600x1700
7.	Жин	1000кг
8.	Үйлдвэрлэсэн огноо	2012-06
9.	Үйлдвэрлэгч	Benefit User (Tian Jin) Technology Development Co.,Ltd

2. Ламинатор төхөөрөмж - НЦҮ-ийн бэлдэцийн хийг сорж, өндөрт температурт нааж, бэхжүүлэх зориулалттай.



Техникийн үзүүлэлт

1.	Загварын нэр	BSL 11.22.00
2.	Серийн дугаар	12.04.Y1563
3.	Чадал	4.5кВт
4.	Ажиллах хүчдэл	380В
5.	Хийн даралт	0.6-0.8МПа
6.	Хэмжээ	1500x2500x1250мм
7.	Вакуумын хязгаар	10МПа
8.	Ажиллах температур	100-180°C
9.	Үйлдвэрлэсэн огноо	2012-04-09
10.	Үйлдвэрлэгч	Qinhuandao Boost Solar Photovoltaic Equipment Co.,Ltd

3. Компрессор буюу хий хуримтлуулах төхөөрөмж- НЦҮ-ийн үйлдвэрт хийг өндөрт даралттай хадгалах, ламинаторт хий өгөх зориулалттай.



Техникийн үзүүлэлт

а. Компрессорын техникийн үзүүлэлт:

1.	Загварын нэр	SEC7A-8
2.	Серийн дугаар	110070797
3.	Чадал	7.5кВт
4.	Ажиллах хүчдэл	380В
5.	Хийн даралт	8 Бар
6.	Хэмжээ	800x620x810мм
7.	Эргэлтийн хурд	1.15м ³ /мин
8.	Зарцуулалт	10.1кВт/(м ³ /мин)
9.	Ажиллах температур	25°C
10.	Жин	220кг
11.	Үйлдвэрлэсэн огноо	2012-04-10
12.	Үйлдвэрлэгч	Shanghai success Engine Compressor Co.,Ltd

б. Хийн хуримтлуур савны техникийн үзүүлэлт:

1.	Лицензийн дугаар	TS2233183-2013
2.	Серийн дугаар	YY120607A1-220
3.	Тооцоот даралт	0.84Па
4.	Тооцоот температур	150°C

5.	Ажиллах хүчдэл	380В
6.	Ажиллах ХИ Даралт	0.8 Па
7.	Эзэлхүүн	0.6м ³
8.	Үйлдвэрлэсэн огноо	2012-06
9.	Үйлдвэрлэгч	Jonway Co., Ltd

4. Модуль тестер төхөөрөмж - НЦҮ-ийн бэлдэцийг ламинатораас гараад хөрсний дараа хиймэл нарны гэрэлд туршилт хийж чадал, гүйдэл, хүчдэл, гэх мэт үзүүлэлтүүдийг шалгах зориулалттай.



Модуль тестерийн техникийн үзүүлэлт:

1.	Загварын нэр	BSMT204
2.	Серийн дугаар	330923434
3.	Чадал	550Вт
4.	Ажиллах хүчдэл	220В
5.	Хийн даралт	0.6-0.8МПа
6.	Хэмжээ	2400x1650x900м
7.	Чийглэг	80%
8.	Ажиллах температур	25°C
9.	Үйлдвэрлэсэн огноо	2012-04-10
10.	Үйлдвэрлэгч	Qinhuandao Boost Solar Photovoltaic Equipment Co., Ltd

1. Монгол-Японы төвийн Бизнесийн Үндсэн сургалтад суух болсон шалтгаан

- Япон менежментийн арга барилаас суралцах
- Борлуулалтаа нэмэгдүүлж компаниа томруулах

2. Бизнесийн үндсэн сургалтад сурсан зүйлээ компанидаа яаж хэрэгжүүлж байна вэ? Компанид гарсан өөрчлөлт

5S хийсэн ажлын байруудаасаа түүвэрлээд танилцуулга оруулав.

1. Подемны хашлаганд анхааруулах пайз хийх

Анхааруулах пайз хийхээс өмнө
/урд тал/



Анхааруулах пайз хийсний дараа
/урд тал/



2. Бараа зөөдөг тэрэгний ТЭМДЭГЛЭГЭЭ

2 дугуйтай болон 4 дугуйтай зөөврийн тэрэгний байрлуулах газрыг цагаан будгаар 3 эгнээ болгон будаж тусгаарлаад, тэмдэглэгээ байрлуулсаны дараа



3. Хүлээн авахад хорго хийх

3ш тавцантай, 6ш тасалгаатай, 4ш гүйдэг хаалгатай, борлуулах болон бэлгэнд өгдөг жижиг хэмжээтэй бараа, бүтээгдэхүүн байрлуулах зорилалттай хорго хийсэн.




Урд тал



Хажуу тал

4. Үйлдвэрт гадны хүн ирэхэд өмсгөх тавчик, малгай, нөмрөг бэлдэх



Тавчикны оронд нэг удаагийн улавч ашиглахаар сонгоод, нэг удаагийн малгай, нэг удаагийн нөмрөг бэлдсэн.

1. Нөмрөг
2. Малгай
3. Амны хаалт

5. Хамгаалалтын дуулганы тавиур хийх

Өмнө



Дараа



6. Агуулах хаягжуулах, тавиур НЭМЖ ХИЙХ

Тавиур 1



Тавиур 2



Тавиур 3
/нэмж хийсэн/



ЗАСВАРЫН ӨРӨӨНИЙ 5S

ӨМНӨ



Тавиур дээр болон доор байрлах цэгцлээгүй сэлбэг, бараа материал

ДАРАА



Бараа материалыг байх ёстой байрлалд байршуулсаны дараах байдал

ӨМНӨ



Засварт ирсэн хот айл хөлдөөгч, угаалгын машин, зурагт, ус тоссон хувин

ДАРАА



Хөлдөөгч засварлахад ашиглах багаж хэрэгсэл

БОРЛУУЛАЛТЫН ӨРӨӨНИЙ АГУУЛАХ

Өмнө



Дараа



ҮЙЛДВЭРТ 5S ХИЙСНИЙ ДАРАА

Өөр өөр газар байсан НЦҮ-үүдийг нэг дор, нэг жаазан дээр томоос жижигрүү өрж байрлуулаад, НЦҮ тус бүрийн үзүүлэлт, агуулахын бүртгэлийн кодийг бичиж наасан.



ҮЙЛДВЭР

Өмнө

Дараа



3. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл

- Компани амжилттай урт удаан хугацаанд оршин тогтнохын үндэс нь хүнээ дээдлэх явдал юм.
- Өндөр сэтгэл ханамжтай ажилтан = өндөр сэтгэл ханамжтай үйлчлүүлэгч
- Хэрэглэгчийн хүлээлтийг хэд дахин давуулсан үйлчилгээ үзүүлж байж үнэнч олон хэрэглэгчтэй ашиг орлого өндөр компани болдог.
- Шинэ болон хуучин ажилтны сургалтыг мэргэжлийн болон хувь хүний хөгжлийн чиглэлээр тогтмол явуулж байх нь маш чухал.
- 3S нь компанийн бүтээмжийг нэмэгдүүлэх гарц юм.
- Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг бүх ажилчдын дунд уралдаан зарлан, хийж хөгжүүлэх бөгөөд шинэ санаа бүрийг хөхиүлэн дэмжиж 10000, 20000 төгрөгөөр хамаагүй урамшуулан дэмжиж байх хэрэгтэй. Шинэ бүтээгдэхүүн бүр зах зээлийг цочроосон шинэлэг байх ёстой.

4. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

Японд хийсэн сургалт маш үр дүнтэй боллоо. Хүн нүдээр үзэж, гараар барьж байж япон менежментийг ойлгодог юм байна. Орчинд нь орж байж япончуудын үнэт зүйлс, зарчмыг ойлгодог юм байна. Бид бүхнийг хөгжил дэвшилд хүргэхийн төлөө хичээнгүйлэн тусалдаг японы ард түмэнд баярлалаа.

5. Сургалтын талаарх сэтгэгдэл, компани хэрэгжүүлж болохуйц жишээ

- Бүх ажилчдын сургалтыг тогтмол хийх, шинэ санааны уралдаан байнга явуулж байх

6. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани эсвэл өөрийн бие дээр)

- Шинэ ажилтныг ажилд авч сургахдаа 5 настай хүүхдэд зааж байгаа мэт аажуухан замаар удаан боловч үр дүнтэй сургах
- Уг ажилтан 2 дахь жилээсээ дараагийн шинэ ажилтандаа зааж сургаж, бэлдэх тогтолцоогоор нэвтрүүлэх
- Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийж, дүгнэж байх

7. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

- Хичээлээ маш сайх хийх, шалгалтаа өндөр оноотой өгч япон явахын төлөө хичээх
- Хоцрох, таслах зэргээр оноогоо хасуулахгүй байх
- Сурсан хичээлээ орой нь гэртээ цээжлэх, давтах
- Нэгэнт цаг заваа зарцуулж сурсных заавал япон явахын төлөө бүх хүчээ дайчлах хэрэгтэй. Япон төвийн япон менежментийн сургалтад сууснаар эхний 30%-ийг ойлгоно. Харин үлдсэн 70%-ийг японд очиж өөрийн биеэр мэдэрснээр япон менежментийг бүрэн ойлгож чадна.

“ЦЭС ХАЙРХАН” ХХК

Нэр: **Ж. Одончимэг**
 Албан тушаал: **Хүний нөөцийн албаны дарга**
 Үндсэн сургалт төгссөн он: **2017**



Компанийн нэр:	Цэс Хайрхан ХХК
Байгуулагдсан он:	2007
Үйл ажиллагааны чиглэл:	Шингэн хүнсний үйлдвэр
Ажилчдын тоо:	65

Компанийн товч танилцуулга

ЦЭС ХАЙРХАН ХХК нь 2007 оноос олон төрлийн жимсний шүүс, дарс болон оргилуун дарс боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байна. 2010 оноос ХБНГУ-н тоног төхөөрөмж, түүхий эд, инновацийг нэвтрүүлж Герман улсын дарс болон хүнсний технологич нартай хамтран ажилласаар ирлээ.

Манай компани 2010 оноос эхлэн Монгол улсын нэрийн хуудас болсон чацаргана жимсээр дарс болон оргилуун дарс үйлдвэрлэж эхэлсэн бөгөөд одоогоор бид уг бүтээгдэхүүнээ Япон болон БНХАУ-н зах зээлд амжилттай нийлүүлж байгаа. Одоогоор бид 52 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.



1. Монгол-Японы төвийн Бизнесийн Үндсэн сургалтад суух болсон шалтгаан

1. Дэлхийд гайхагдсан Япон менежментийг сурахыг хүссэн
2. Япончууд яаж, яагаад төгс төгөлдөр бүтээгдэхүүн үйлдвэрлээд байгааг мэдэхийг хүссэн ☺

2. Бизнесийн үндсэн сургалтад сурсан зүйлээ компанидаа яаж хэрэгжүүлж байна вэ? Компанид гарсан өөрчлөлт

2017 оны 3 сард МЯТ-ийн сургалт дууссаны дараа өөрийн байгууллага дээрээ сурсан зүйлээсээ хэрэгжүүлж эхэлсэн.

Жишээ нь: Компанийнхаа анхны OGSM (Objectives Goals Strategies Measures) -г 2017 оны сүүлээр хийж байгууллагынхаа анхны Эрхэм зорилго, Алсын хараа, Үнэт зүйлсийг тодорхойллоо. Түүнийхээ дагуу энэ жилийнхээ байгууллага, хэлтэс, хувь хүн тус бүрийнхээ төлөвлөгөөг жил, улирал, сараар нь гаргаж үр дүн, ажлын явцыг долоо хоногоор хэлэлцэж байна. Ажлын үр дүн хэлэлцээд эхлэхээр үнэлгээний систем нэвтэрч эхлэх хэрэгтэй болж, бид KPI болон MBO үнэлгээний системийг хэрэгжүүлж эхлээд байна.

Сургалтад хамрагдсанаар байгууллагынхаа зорилго, алсын хараагаа тодорхой болгож ажилчдаа алсын хараа руугаа чиглүүлэн хөдөлгөж эхэлсэн.

3. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл

Япончууд ажлыг урт хугацааны няхуур гаргасан судалгаа шинжилгээн дээр үндэслэн, маш нарийн гаргасан төлөвлөгөө, хүнээ сургаж хөгжүүлэх систем болон байнгийн зохистой дадал дээр хэрэгжүүлдэг юм байна. Сайн компани байхын тулд хүчирхэг багтай байх хэрэгтэй, хүчирхэг багтай байхын тулд хүнээ хөгжүүлдэг, чадавхийг нь сайжруулдаг байх хэрэгтэй.

Япон менежмент нь өөрөө хүн төвтэй менежмент бөгөөд байгууллагын ажилчид болон тэдний гэр бүл, компанийн харилцагчид болон тэдний гэр бүлийн аз жаргалыг 1-рт тавьдаг. Ингэснээр аз жаргалтай ажилчид нь ар гэртээ санаа зоволгүйгээр сэтгэл санаа өөдрөгөөр ажилдаа 100% өөрийгөө зориулдаг байна. Ингээд байгууллагын ажилчид 100% сэтгэл ханамжтайгаар бүтээгдэхүүн үйлчилгээгээ үзүүлж, тэр сэтгэл шингэсэн төгс бүтээгдэхүүнийг худалдан авсан үйлчлүүлэгч нь тэр компанийн сэтгэл ханамжтай үйлчлүүлэгч болдог.

Япон компаниуд бас нийгэмдээ хувь нэмрээ оруулсан, нийгмийн үнэ цэнийг нэмсэн байгууллага болохыг зорьдог юм. Энэ нь ажилчдаа хөгжүүлэх, тэдний өмнө болон тэдний гэр бүлийн өмнө хүлээсэн хариуцлага, улс нийгэмдээ үнэнчээр татвар төлж, бас олон шинэ ажлын байрыг энгийн иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нэмэх, байгаль орчиндоо ээлтэй байх гэсэн үг юм.

Байгууллагын бүх алба, хэлтэс, ажилчдын ажил болон төлөвлөгөө нь ил, ойлгомжтой, хэмжиж дүгнэхэд амар байх бөгөөд **Plan - Do - Check and Action** (PDCA method) гэсэн аргаар явагдана. Ингэснээр ажлын байран дээр зогсолтгүй сайжруулалт явагддаг юм байна.

4. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

Дадлага сургалтнаас төлөвлөлтийг маш сайн хийх хэрэгтэй гэж ойлгосон. Бүх ажлыг төлөвлөгөөний дагуу хийж байж 7 МҮДА болон ажил дээрх хэвийн бус байдал ил тод болно. Эдгээрийг ил болгосноор 5S хэрэгжүүлэх үндэс суурь нь болно. 5S хэрэгжүүлж, тууштай баримталснаар хэвийн бус байдал илрэх, ажил хийхэд ойлгомжтой хялбар болох, гэмтэл хорогдол гологдол багасаж бүтээгдэхүүний чанар сайжирна.

5. Сургалтын талаарх сэтгэгдэл, компани хэрэгжүүлж болохуйц жишээ

Дадлага сургалт маш их үр өгөөжтэй, үр дүнтэй болсон. Мянга сонсохоос нэг үз гэдэгчлэн өөрийн биеэр газар дээр нь очиж урам зоригийг тэднээс авч оргилуун сэтгэлээр шинэ ажлын төлөвлөгөө гаргаж байна.

Одоогоор зөвхөн төлөвлөгөөгөө нарийвчлан алба хэлтэс, баг хүн тус бүрээр нь долоо долоо хоногоор нь гаргаад хянаад явж байна. Бас хүмүүсээ урамшуулан мотивацижуулах зорилгоор шагналт уралдаан болон тэмцээнүүдийг хуваарь гарган явж байна.

6. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани эсвэл өөрийн бие дээр)

Дараагийн хийхээр зэхэж буй ажил маань 3S-г хэрэгжүүлэх. Комисс байгуулаад нийт ажилчдаа багаар хуваан ажлыг нь долоо хоногоор үнэлж явна. Бас хүний нөөцийг хөгжүүлэх гарын авлага боловсруулах, шинээр ажилд орсон хүнийг анхнаас нь сургах дасан зохицох хөтөлбөр боловсруулахаар төлөвлөж байна. Сургалтын хуваариудыг хүн тус бүр дээр жилээр нь гаргана.

7. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Сургалтын явцад хийх ажлуудаа цаг хугацаатай нь төлөвлөх хэрэгтэй. Тэгээд тэрийгээ хэрэгжүүлэхийг зориорой. Хугацаа алдах тусам сарнин мартагдах магадлал өндөр. Тэнд сурсан мэдсэн болгон энд хөрсөн дээр буухгүй нь ойлгомжтой тэгэхээр нөхцөл байдалдаа тохируулаарай.

“АНЖЕЛ СТАР” ХХК

Нэр: Г.Болд
Албан тушаал: Ерөнхий захирал
Үндсэн сургалт төгссөн он: 2014



Компанийн нэр:	Анжел Стар ХХК
Байгуулагдсан он, үйл ажиллагааны чиглэл:	2004 оноос эхлэн “Барилгын цонх, хаалганы үйлдвэрлэл” 2014 оноос “Цонх, хаалганы үндсэн болон туслах материалын худалдаа”
Ажилчдын тоо:	25

Компанийн товч танилцуулга

“Анжел стар” ХХК нь 2003 онд анх үүсгэн байгуулагдаж 2004 оноос өнөөг хүртэл хуванцар цонх, хаалганы үйлдвэрлэл 14 жил тасралтгүй явуулж байгаа бөгөөд 2014 онд цонх, хаалганы үндсэн болон туслах материал худалдах үйл ажиллагааг явуулж эхэлсэн.

Анх манай компани 3 ажилтантай үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол одоогийн байдлаар 25 ажилтантай салбартаа тэргүүлж чадахуйц чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх “STARWINDOW” үйлдвэр болон цонх, хаалганы тоноглол, жийргэвч резин, шил, цавуу бусад туслах материалуудыг худалдаалах “WINDOW MARKET” дэлгүүрээр Монгол орны барилгын цонх, хаалганы зах зээл дээр ажиллаж байгаа 300 орчим үйлдвэрүүдийн 60% хувьд нь нийлүүлж байна.

Бид үйлдвэрлэлээ ГОСТ-30673:99 стандартын шаардлага хангасан БНХАУ-ын “SHIDE” болон ОХУ-ын “КРАУСС” брэндийн Монгол орны болон Сибирийн эрс тэс уур амьсгалтай газарт зориулан үйлдвэрлэсэн дулаан хадгалах 4 болон 5 тасалгаатай материалыг Туркийн “FORNAX” /ISO 9001:2008/ брэндийн нугас түгжээгээр тоноглон, Туркийн “PIKASAN” /ISO 9001:2000/ фирмийн EPDM маркийн резин жийргэвчүүд ашиглан 2 болон 3 давхар шилтэйгээр мөрдвөл зохих үйлдвэрлэлийн технологийн горим, үндсэн зарчмыг баримтлан жилдээ 10000 м2 цонх, хаалгыг үйлдвэрлэж байна. Мөн Турк улсын “FORNAX”, “PEN-KID”, “PIKASAN” БНХАУ-ын “SILANDE” зэрэг брэндүүдийн Монгол дахь албан ёсны төлөөлөгчөөр ажиллаж байна

1. Монгол-Японы төвийн Бизнесийн Үндсэн сургалтад суух болсон шалтгаан

1. Ажилчдын хөдөлмөр оролцооны коэффициентийг тооцоолох
2. Багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх
3. Маркетинг сайжруулж, борлуулалтыг нэмэгдүүлэх
4. Үйлдвэрийн байр болон дэлгүүрт 5S хэвшүүлэх
5. Компанийн соёлыг төлөвшүүлэх
6. Үйлдвэрийн процессийн зураглалыг оновчтой болгох

2. Бизнесийн үндсэн сургалтад сурсан зүйлээ компанидаа яаж хэрэгжүүлж байна вэ?

1. Дэлгүүр болон үйлдвэрийн борлуулалтыг нэмэгдүүлсэн
2. Дэлгүүрийн барааны зохион байгуулалт, өрөлтийг сайжруулсан
3. Үйлдвэрт 5S хэрэгжүүлж, эмх цэгцтэй байхад үргэлжлүүлэн суралцаж байна
4. Ажилчдын багаар ажиллах чадварыг сайжруулахад маш их өөрчлөлт гарч байна.



Барааны өрөлт, хураалт



Багийн ярилцлага, хамтын ажиллагаа



3S ба Ангилан ялгалт



Ажилчдад зориулсан сургалт сименар

3. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл

Асуудал 1: 5S хэрэгжүүлэх

1. Ашгийн эх үндэс нь эрэмбэ, эмх цэгц, цэвэрлэгээ, цэвэр цэмцгэрт оршдгийг суралцлаа.
2. 3S болон 5S хэрэгжүүлсэн олон үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцаж, цаашид өөрийн компанийн хэмжээнд хэрхэн энэ хөдөлгөөнийг нэвтрүүлж, тууштай хэрэгжүүлэх талаар аргачлалтай танилцлаа.



Асуудал 2: Үйлдвэрлэлийн процесс, хүний нөөц

1. Ажлын байран дээрх зардал буюу МУДА илрүүлэх аргачлалууд
2. Үйл ажиллагааг сайжруулах кайзэн хэрхэн хийх арга
3. Үргүй зардал болон сайжруулалтыг хэрхэн бүртгэх, мэдээллэх, дүн шинжилгээ хийх аргуудаас суралцлаа



Асуудал 3: Компанийн соёл

1. Хүнийг хүндэтгэдэг менежментийн тогтолцоо, байгууллагын үнэ цэнийн тухай ойлголтыг багийнхантайгаа ойлгуулж ярилцсанаар компанийн соёлыг төлөвшүүлнэ.
2. Ажилтнаа хайрлах, тав тухтай ажиллуулах талаар сэтгэл гарган ажиллах, тэднийг сэтгэл ханамжтай байх нөхцөлийг бүрдүүлэхийг хичээж ажиллана.



КОМПАНИЙН МЕНЕЖМЕНТ БОЛ

1. Ажилтан ба түүний гэр бүл
2. Харилцагч ба түүний гэр бүл
3. Өнөөдрийн болон ирээдүйн үйлчлүүлэгч
4. Орон нутгийн иргэд
5. Хувьцаа эзэмшигч нарын "АЗ ЖАРГАЛЫН ТӨЛӨӨ" байх ёстой.

4. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

Япон дахь дадлага сургалт маш их үр өгөөжтэй болсон нь бидний танхимаар олж авсан онолын мэдлэгийг практиктай хослуулсантай холбоотой гэж үзэж байна. Ингэснээр бид үйлдвэрлэлийн удирдлагын чиглэлээр олж авсан мэдээлэл, туршлагаа хамтран ажиллагсдадаа, ажилчдадаа зааж сургахад үр дүнд хүрнэ гэдэгтэй итгэлтэй байна.

5. Сургалтын талаарх сэтгэгдэл, компани хэрэгжүүлж болохуйц жишээ


5. ТАНАКА ТЕК

3S гэж зөвхөн эрэмблэх, цэгцлэх, цэвэрлэх талаар яригддаг зүйл биш 3S-ыг хэрэгжүүлэх нь "Аливааг зөв бодож, ойлгох аргыг үргэлж эрж хайж, эзэмших" мөн чанарыг ойлгох гэж үздэг энэ компанийн ажлын байран дээрээ хийсэн сайжруулалт, хэрэгжүүлсэн ангилан ялгалт, эмхлэлтийн жишээгээр өөрийн ажил дээр хэрэгжүүлнэ.




6. ТОЁОТА L&F

- Тоёотагийн 4S гэж нэрлээд хэрэгжүүлж буй ангилан ялгах, эмхлэх цэгцлэх, цэвэрлэх, дахин цэвэрлэх ажиллагаа нь манайд тасралтгүй хэрэгжүүлэх шаардлагатай ажил гэж үзсэн.
- Мөн энэ компанийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд гардаг 7 МУДА-г арилгах арга замыг өөрийн компанид хэрэгжүүлэх сэдэл төрлөө. Ялангуяа Тоёота компани үйлдлийн мудагаа 50%-д хүргэсэн байгаа нь сайхан санагдлаа.



7. МИНАГАВА КЕНТАРО ПРОФЕССОР

Кайзэн хийхэд анхаарах зүйлс, ECRS аргачлал, хөдөлгөөний МУДА-г арилгах дадлага ажил зэрэг нь үр өгөөжтэй байсан ба өөрийн компанийн сургалтын хөтөлбөр тэдгээр аргыг нэвтрүүлэх мөн профессор Минагава Кентаро-г Монголд урьж компаниудад ажиллуулах, зөвлөгөө авах хүсэлтэй байна.



6. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани эсвэл өөрийн бие дээр)

- 6.1 Японд үйлдвэрлэлийн дадлага сургалтаар танилцсан болон мэдсэн мэдээллийн талаар ажиллагсад болон бусад багийнхандаа компани нэг бүрээр тайлан танилцуулж, үйлдвэрлэл ямар түвшинд ажиллаж болдог талаар мэдээлэл өгнө.
- 6.2 Байгууллагын сургалтын төлөвлөгөөнд үйлдвэрлэлийн менежментийн талаарх гадаад болон дотоод сургалтуудыг төлөвлөж, байгууллагын ахлах түвшний менежерүүдийг МЯТ-ийн Бизнесийн удирдлага, Үйлдвэрийн удирдлага зэрэг сургалтуудад хамруулна.
- 6.3 Байгууллага дээр үүсдэг аливаа асуудлуудыг илрүүлэх, чухал байдлаар эрэмбэлж гаргах, асуудал тус бүрийг шийдэх арга замыг багаараа гаргах арга барилд суралцаж, мэргэжлийн багшийн удирдлага дор хэд хэдэн асуудлыг шийдвэрлэж ажиллана.
- 6.4 Үйлдвэрлэлийн хамт олонтойгоо хамтран одоогийн үйлдвэрлэлийн процесс тус бүрт зураг авалт хийж, хөдөлгөөний болон зөөвөрлөлтийн мудаг олж илрүүлж, эрэмбэлэн, илрүүлсэн мудаг арилгах арга замыг хамтдаа тодорхойлж, хэрэгжүүлнэ.
- 6.5 Хүнийг хүндэтгэдэг менежментийг тогтолцооны талаар сургалт явуулна. Мөн ажиллагсдынхаа тав тухтай ажиллах амрах нөхцөл байдлыг сайжруулах үүднээс усанд орох хэсэг ... зэргийг тохижуулан ашиглалтад оруулахаар бэлтгээд байна.
- 6.6 Байгууллагын үнэ цэнийн тухай ойлголтыг тодорхойлон, нийт ажиллагсад танилцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх ба байгууллагын үнэт зүйл болох ажилтан нэг бүрд ХУВИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ/АМЬДРАЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ гаргахад нь тусалж, хамтдаа хөгжих эхлэлийг бий болгоно.
- 6.7 Хоггүй хамт олон болох зорилтын дор байгууллагын үйл ажиллагаанаас үүсэж буй хог хаягдлыг ангилах, цуглуулах, хогийн савжуулах ажиллагааг хэрэгжүүлж, хаягдалгүй хамт олон болохыг зорьж ажиллана.

7. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

1. Цаг баримтлах
2. Бусдыг хүндэтгэх
3. Хөтөлбөртэй урьдчилан сайн танилцах
4. Сургалтын үед ойлгомжгүй санагдсан зүйлээ тэр дор нь асууж лавлах

“ВИТАФИТ ИМПЕКС” ХХК

Нэр: **О.Мөнхжаргал**
 Албан тушаал: **Түгээлтийн албаны дарга**
 Үндсэн сургалт төгссөн он: **2018**



Компанийн нэр:	Витафит Импекс ХХК
Байгуулагдсан он:	2005
Үйл ажиллагааны чиглэл:	Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт
Ажилчдын тоо:	250

Компанийн товч танилцуулга

“Витафит Импекс” ХХК нь Витафит группын салбар компани бөгөөд сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын үйл ажиллагаа явуулдаг. Тус компани нь Монголын сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээл дээр 2009 оноос Өглөө брэндийн сүү, Гоё брэндийн тараг, иогуртнууд, 2015 онд Гэр брэндийн элгэн тараг, 2016 онд Өлзий брэндийн сүү, тараг, иогурт, цөцгийн тос, зөөхий мөн 2017 онд Пороро брэндийн монгол аарцаар хийсэн сырок, иогуртыг үйлдэрлэн борлуулж байна. Манай компани 2018 оноос шинээр 20 гаруй нэр төрлийн зайрмаг үйлдвэрлэн худалдаанд гаргаад байна.

“Витафит Импекс” ХХК нь 250 гаруй ажилтантай ба үйлдвэрлэл 24 цагаар тасралтгүй явагддаг.

2011 оноос MNS ISO 9001:2010 чанарын удирдлагын тогтолцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байгаа ба 2016 онд Хүнсний аюулгүй байдлын ISO 22000 тогтолцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.



1. Монгол-Японы төвийн Бизнесийн Үндсэн сургалтад суух болсон шалтгаан

1. Япон маягийн менежментийн талаар онолын мэдлэгтэй болох
2. Компанид тулгарч байгаа асуудлуудын хариуг олох

2. Бизнесийн үндсэн сургалтад сурсан зүйлээ компанидаа яаж хэрэгжүүлж байна вэ? Компанид гарсан өөрчлөлт

Компанийн стратегийг боловсруулахад гар бие оролцсон. Мөн өөрийн хариуцсан албаны ажилчдын KPI үзүүлэлтийг дүгнэх үзүүлэлтүүдийг шинэчилсэн.

Автын механикуудын багаж ашиглалтыг сайжруулсан.



3. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл

Япон компаниудын гол философи нь ажилчдаа дэмжиж байж өөрөө сайхан амьдрах

Үүрэг хариуцлага, Зорилго, Үнэ цэнийн үзэл

【Компаний үүрэг хариуцлага】
"Манай компаний бүтээгдэхүүнээр дамжуулан нийгмийн хүмүүс хоорондын харилцааг улам баяжуулан хөгжүүлэх"

【Бид нарын зорилт】

- Ажил хийсний үр бүтээлээ мэдрч чаддаг ажлын байрны орчинг бүрдүүлэн, бүх ажилчдыг мэдрэгдэж болж ажиллахыг зорин
- Хүн ба дэлхийн орчинд зэрэг, сэтгэл татам бүтээгдэхүүнийг бий болгож дэлхийн хүмүүсийн үйлчлүүлэх дуртай компани байх

【Нэгдсэн үнэ цэний үзэлтэй】

- Бусдадтай сайн харилцаж чаддаг
- Өөрчлөлт хийхийг зорьж, худалх хүч болж ажиллах
- Ажилт хөгжилтэй сонирхолтой хийх аргыг санаачлах
- Эвэрлэл, хамтын ажиллагааг дээдлэх
- Зорилгыг биелүүлэх эрмэлзэлтэй байх
- Даруу, эрхэм чанартай байх
- Гайхуулж, сэтгэлийг хөдөлгөж чаддаг ажлыг хийх ажиллах
- Бие сэтгэлийн эрүүл мэнд, дэлхийн орчноо хайрлах
- Өөрийн гэсэн бодолтой байж, түүнийг бусдад илэрхийлэх

Menegmentdээ эрхэмлэдэг зүйл

«Манай компани нийгэмд хэрэгтэй хүнийг бэлтгэхийг зорьж ажиллана»

- ◆ Компани бол зөвхөн ашгийн төлөө ажиллах биш.
- ◆ Нийгэмдээ хувь нэмэр оруулах нь компаний зорилго юм.
- ◆ Ашиг гэдэг нь компаний үйл ажиллагаа явуулахад хэрэгтэй зүйл.
- ◆ Компани бол хүмүүсийг аз жаргалтай амьдрахад тус болж чаддаг байх үнэ цэнээ олно.
- ◆ Аливаа зүйлийн суурь үндэс бол хүн юм.
- ◆ Юмны үнэ цэнийг зөв ойлгож чаддаг хүнийг бэлтгэж чадахгүй бол нийгэмд хэрэгтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэж чадахгүй.
- ◆ Мөн компани удаан хугацаагаар оршин байж чадахгүй.
- ◆ Мэдлэг, технологи, мөнгө, эд зүйл г.м.-ийн зохистой ашиглалт нь хүнээс хамаарах асуудал юм.

Хүнээ сургаж хөгжүүлснээр нийгэмээ сайн сайхан болгох

Хөгжье, хөгжүүлье, хамтдаа хөгжцгөөе

Анхаарал тавьсанд баярлалаа

"Value Engineering буюу чанарын инженерчлэлийн аргачлал"-ын сэдвээр компаний дотоод сургалтын үе

Халуун сэтгэлээ илтгэх тэмцээн

• Баг тус бүрээр "бүтээгдэхүүн болгоо!" гэсэн чин сэтгэлээ тайлагнаж, бүх орлогчдын саналаар шагнадаг.

©2018 ГогоФүүкү ХК

- Аливаа бизнест **Мүдa** байдаг ба түүнийг **таньж мэдэж, арилгах** нь чухал.
- **5S-** нь ерөнхийдөө ажилчдад **ажлын таатай орчныг** бий болгож, **ажлын бүтээмжийг дээшлүүлдэг.**
- **Компани** оршин тогтнох болон **улс орон** нь хөгжилтэй байх гэдэг нь **хүндэтгэл, шударга байдал, хамтын зүтгэлээс** хамаардаг.
- **Хэрэглэгчийн сэтгэл** ханамж нь **ажилчдын сэтгэл ханамжаас** шалтгаална.
- **Цаг барих** нь улс орны хөгжил болон **хувь хүний хөгжилтэй** шууд хамааралтай.

1. Товчоогийн үйлдвэрлэлийн аргачлал болон 4S

Мүдa гэдэг нь: Нэмүү өртгийг дээшлүүлэхгүй бүх зүйл

"Ажиллах" болон "Хөдлөх"

"Ажиллах" гэдэг нь, хүн өөрийн үүрэг, багтаал, ажил, ажилтны өртгийг дээшлүүлэхийн тулд, нь болгохыг зорьж, өөрийн өртгийг "Хөдлөх" гэдэг нь, нэмүү өртгийг дээшлүүлэхгүй, өөрийн хөдөлгөөнөөс цэвэрлэх.

Кайзен хийгчдээр ажил нэмэх → Хөдөлгөөн хүчээр Кайзен хийж "Хөдөл" ийг "Ажиллах" болгож өөрчлөх нь болгохыг зорьж байх



МЕНЕЖМЕНТИЙН ЧИГЛЭЛ

CIS = EIS

Customer Impressive Satisfaction Employ Impressive Satisfaction

Хэрэглэгчийн сэтгэл ханамж = Ажилчдын сэтгэл ханамж

4. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

Энэхүү сургалт нь практик дээр суурилсан, бодит байдал дээр нүдээр үзэж танилцаж байгаа учир онолоос авсан мэдлэгийг **хэрэгжүүлэхэд илүү бодитой, сурсан зүйлээ бататгахад амар ойлгомжтой байсан.**

Япон компаниудын ажилчдаа байнга, тасралтгүй сургаж, хүндэлж, дэмжиж байгаа нь мөн нийгмээ байнга бодож нийгэмдээ хийж байгаа үйлдэл зэрэг нь **Япон улсын өнөөгийн хөгжлийн эх үүсвэр байсан болов уу.**

5. Сургалтын талаарх сэтгэгдэл, компани хэрэгжүүлж болохуйц жишээ

Хичээлийг онол, практик хослуулж, мөн жишээг бодит компани дээр үзүүлж байсан нь их үр дүнтэй болсон. Мөн сургалт явуулж байгаа арга барил нь суралцагчдад илүү хялбар хүртээмжтэй байсан.

Компаний хувьд стратеги төлөвлөгөөгөө дахин нягталж өөрчлөхөөр болсон.



Үйлдвэрийн ариун цэврийн өрөөнд ашиглах

боломжтой.

6. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга(Компани эсвэл өөрийн бие дээр)

- Шинээр орж ирж буй ажилтанд зориулсан ойлгомжтой тодорхой гарын авлагатай болох,
- Өөрийн албаны ажилчдыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулахаар төлөвлөж байна.
- Мөн 3S –г сэлбэгийн өрөө, автын механикуудын өрөө, борлуулалтын агуулахад хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

7. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Сургалтаас сурсан зүйлээ байнга зургаар баталгаажуулж өөртөө авах хэрэгтэй. Мөн цаг алдахгүй хэрэгжүүлэх хэрэгтэй. Хэрэгжүүлж болохуйц ажлыг баг томилон хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй.



“МОНГОЛ ВАНН КОНСТРАКШН” ХХК

Нэр: **Ж.Мөнхцэцэг**
 Албан тушаал: **Ерөнхий захирал**
 Үндсэн сургалт төгссөн он: **2018**



Компанийн нэр:	Монгол ванн констракшн ХХК
Байгуулагдсан он:	2012
Үйл ажиллагааны чиглэл:	Шахмал чулуун ванн, угаалтуурын үйлдвэрлэл
Ажилчдын тоо:	19

Компанийн товч танилцуулга



Үндэсний үйлдвэрлэгч “МОНГОЛ ВАНН КОНСТРАКШН” ХХК нь 2012 оны 6 дугаар сард “Гантиг ванн констракшн” ХХК нэртэйгээр байгуулагдсан бөгөөд импортын бүтээгдэхүүнийг орлох чанартай, өнгө загварын өргөн сонголттой шахмал чулуун ванн, угаалтуурыг БНСУ-ын баталгаат түүхий эд, эх орныхоо байгалийн чулууг ашиглан үйлдвэрлэж байна. Манай компанийн гүйцэтгэх захирал Л.Алтангэрэл нь БНСУ-ын Намъянжү хотод 2007-2011 оны хооронд ванны үйлдвэрт гэрээт ажилтнаар ажиллаж байгаад 2011 онд эх орондоо буцаж ирсэн бөгөөд барилгажилт хурдацтай хөгжиж буй энэ цаг үед эзэмшсэн мэдлэг чадвар дээрээ тулгуурлан импортыг орлосон бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр шийдэж энэхүү компанийг үүсгэн байгуулсан билээ.

Бид ажлын 1-2 өдөрт багтаан хэрэглэгчийн хүссэн өнгө, загвар, хэмжээгээр чанарын өндөр түвшинд үйлдвэрлэдэг. Өнөөдрийг хүртэл нийслэл болон орон нутагт шинээр ашиглалтанд орж буй 100 гаруй орон сууцны барилгатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласнаас гадна гэр орондоо засвар хийж буй айл өрхүүдэд монгол чулуун ванн, угаалтуураа нийлүүлсээр ирлээ. Цаашид бид өсөн нэмэгдсээр байгаа хэрэглэгчдийнхээ тоог тогтвортой хадгалахын тулд загвар дизайнаа улам өргөн сонголттой болгож, бүтээгдэхүүнийхээ чанарт тогтмол анхаарч, хэрэглэгчдийн итгэлийг хүлээсэн, үндэсний тэргүүлэгч үйлдвэр болох зорилт тавин ажиллаж байна.

Бид үүсэн байгуулагдсанаас хойшхи 5 жилийн хугацаанд,

- Монголын Маркетинг Менежментийн Хүрээлэнгээс хоёр жил тутам зохион байгуулдаг Гранд экспо шалгаруулалтанд 2015 оны “Барилгын материалын топ үйлдвэрлэгч”,
- БХБЯ, Барилгын Хөгжлийн Төв болон Мишээл экспогоос жил бүр зохион байгуулдаг “Улаанбаатар Барилга” үзэсгэлэнгээс 2016 оны Барилгын материалын шилдэг үйлдвэрлэгчээр шалгаран амжилттай ажиллаж байна.

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАНИЛЦУУЛГА

Үйлдвэрлэх үндсэн бүтээгдэхүүн нь 1-2 метрийн урттай хориод төрлийн ванн, 10 гаруй төрлийн угаалтуур үйлдвэрлэж байгаа бөгөөд бүх бүтээгдэхүүнийг 20 гаруй өнгөний сонголттойгоор үйлдвэрлэж байна. Түүнчлэн тухайн хэрэглэгчийн тав тухыг бүрэн хангасан бүтээгдэхүүн нийлүүлэх үүднээс захиалагчийн хүсэлтээр усан массаж буюу жакузиар тоноглох, дэр бариул нэмэлтээр суулгах, хүргэлт угсралтын үйлчилгээг хийж гүйцэтгэх, засвар үйлчилгээ үзүүлэх зэрэг нэмэлт үйлчилгээ бий болгон ажиллаж байна.

Давуу тал:

- ✓ БНСУ-ын стандарт болон тус улсын технологийн дагуу үйлдвэрлэдэг.
- ✓ Бүтээгдэхүүний гол орц дүүргэгч материал нь байгалийн чулуу учир бат бөх, эдэлгээ сайтай, хүний биед сөрөг нөлөөгүй.
- ✓ Европын импортын бүтээгдэхүүнтэй харьцуулахад үнэ хямд, БНХАУ-ын бүтээгдэхүүнтэй харьцуулахад байгалийн чанартай материалтай, үнэ ойролцоо.
- ✓ Үндсэн болон завсрын өнгө, судалтай болон саатай зэрэг өнгөний өргөн сонголттой.
- ✓ Хэрэглэгчдийн хүссэн хэмжээгээр бүтээгдэхүүний уртаас хасч тайрч, догол гаргаж өгөх боломжтой.
- ✓ Бүх ванн халтирахаас сэргийлсэн товгор хээ болон өөр өөрийн ялгарах хэв загвартай.
- ✓ Ванн нь нүүр буюу хаалттайгаа хамт гардаг учир өнгө үзэмжтэй. Ванны нүүр хийх гэж худалдан авагч давхар цаг алдаж, плита, цемент зэрэг зүйл худалдан авч нэмэлт зардал гаргах шаардлагагүй.
- ✓ Түүнчлэн энэхүү зориулалтын ванны нүүрийг авч хэрэглэж болдог тул сантехникийн аливаа хүндрэл гарсан үед тохиромжтой.
- ✓ Захиалгын тоо, хэмжээнээс хамаарч бүтээгдэхүүний үнэ, төлбөрийн нөхцөл, урамшууллын уян хатан бодлого барьдаг.
- ✓ Харилцагч байгууллагуудад гэрээний урамшуулал болгож хүргэлт, суурилуулалтын үйлчилгээг үнэгүй хийж өгч, үйлдвэрийн баталгаа гаргадаг.



1. Монгол-Японы төвийн Бизнесийн Үндсэн сургалтад суух болсон шалтгаан

1. Үйлдвэрлэлээ удирдах онолын суурь мэдлэгтэй болох
2. Компанидаа япон маягийн үйлдвэрлэлийн менежментийг нэвтрүүлэх

2. Бизнесийн үндсэн сургалтад сурсан зүйлээ компанидаа яаж хэрэгжүүлж байна вэ? Компанид гарсан өөрчлөлт

Үйлдвэрлэлийн алдааг арилгах үр ашиггүй зардлууд буюу 7 мудагийн талаарх ойлголтыг ажилчдадаа танилцуулсан. 3S, 5S, Кайзэны талаар мэдлэгтэй болсон. Дунд түвшний менежерүүдээ байгууллагын ойрын болон дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах явцад оролцуулж байна. Мөн бүтээмж, үр чадвараар үнэлэх системийг нэвтрүүлэхээр судалж байна.

Санхүүгийн тайландаа дүн шинжилгээ хийж, хэрэгцээгүй зардлуудыг бууруулахаар ажиллаж байна.

3. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл

3S-ийг нэвтрүүлэх, хэвшүүлэх, идэвхжүүлэх

Манай компанийн эрхэм зорилгодоо хүрэх зам бол 3S гэдгийг ойлгосон. 3S нь цэвэр цэмцгэр байдал төдий биш, ажлын үр бүтээмжийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэл үйлчилгээний алдааг багасгах бодит үр дүн дагуулах ажил юм. Тиймээс ажилчдадаа 3S-ын талаар танилцуулга сургалт орж, үсэг тоо холилдсон хүснэгтээр тоглоомын аргаар 1S, 2S, 3S-ын талаар ойлголт өгсөн нь ажилчдад маш их таалагдсан бөгөөд 3S-ын хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Цаашид нийт ажилчдыг багийн хуваарьт оруулж, дүгнэж, урамшуулах замаар 3S-ыг хэвшил болгохоор зорьж байна.

Мүда-г арилгах

Цаашид Мүдагийн талаарх ойлголтыг ажилчдадаа ойлгуулж, сургах бөгөөд мүда арилгах, шинэлэг санаа дэвшүүлэх уралдааныг зарласан.

Хамгийн гол нь Just in time буюу Цагийн ажлыг цагт нь хийх

Аливаа ажлыг хойшлуулахгүй хийх нь хамгийн чухал болохыг өдөр тутмын ажилдаа мэдэрч ойлгож байгаа бөгөөд энэ зарчмыг өөртөө болон ажилчдадаа хэвшил болгохыг зорьж байна. Аливаа ажлыг цагт нь хийгээгүйгээс сайтар боловсруулсан төлөвлөгөө хэрэггүй цаас болон үлдэж, байгууллагын зорилго биелэхгүй, ажилчид назгайрч, мүда нэмэгдэх эрсдэлтэй.

Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх

Япон улсад үйлдвэрүүдээр орж танилцаад МЯТ-ийн үндсэн сургалтаар сурсан хүний нөөцөө хөгжүүлэх, идэвхжүүлэх суурь мэдлэгээ хэрхэн өөрийн үйлдвэр дээр хэрэгжүүлэх арга замаа олж харсан. Үүний тулд хэрэглэгч, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг өндөр байлгахын тулд өөрийн ажилчдын ажилдаа хандах, байгууллагаа харах сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, ар гэрт нь ч тодорхой хэмжээгээр анхаарал хандуулах шаардлагатай гэдгийг ойлгосон. Сэтгэл ханамжтай ажилтнаас чин сэтгэлийн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ гарна гэж итгэж байна.

4. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

3S-ыг бүрэн хэрэгжүүлэх ажлууд хийгдэж байна.

3 салбар дэлгүүрийн худалдагчийг өөр өөрийн салбар дээр 3S-ыг хэрэгжүүлэхийг даалгавар болгож, төлөвлөгөөгүй буюу гэнэтийн хяналтаар шалгаж дүгнэж, үр дүнг байгууллагын фэйсбүүк группт мэдээлэл болгон нийт хамт олонд хүргэж байна. Үйлдвэрийн ажилчдаа 5, 5 хүнтэй 3 баг болгон хувааж, хариуцах хэсэг, хэрэгжүүлэх цаг, хяналт тавих зэргийг тодорхой болгож өгсөн. Өөрсдийн ажиллах хэсэгт багаж хэрэгслийн самбар/тавиуртай болсон. Өдөр бүр орой 10 минут, долоо хоногийн Бямба гарагт 20 минутын тогтмол цэвэрлэгээ хийж, 3S-ын баг нь 7 хоног бүр хэрэгжилтийг шалгана. Шалгах хүснэгт болон 3S-ын самбартай болсон.

Хамгийн их гомдол дагуулж, гологдол гарч байгаа бүтээгдэхүүн, асуудал дээр 5 удаа яагаад шинжилгээг ашиглан асуудлын шалтгааныг арилгахыг зорьж байна. Үүний тулд ванн үйлдвэрлэхээс наанадаж 24 цагийн өмнө чулууг хүйтэн агуулахаас үйлдвэрийн дулаан байранд оруулж бэлдэх, шигшүүрт шигшиж чулууг шүүх ажиллагааг тогтмолжуулах, хатаалгын өрөөний температурыг ээлжийн ахлагч нар тогтмол хянах зэрэг зүйлсийг ярилцаж дүгнэсэн.

5. Сургалтын талаарх сэтгэгдэл, компани хэрэгжүүлж болохуйц жишээ

Бүх сургалтууд шууд компани, үйлдвэрүүд дээр болсон нь шууд санаа авч хэрэгжүүлж болохуйц маш үр дүнтэй байсан. Ялангуяа ЖДҮ-ийн хувьд “Танака тек” компани дээрх сургалт үйлдвэр дээрх ажлын байрны зохион байгуулалт ямар байвал зохих талаарх бодит мэдлэгийг өгч, өөрчлөлтийг хийж чадах итгэлийг маш их төрүүлсэн.

6. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани эсвэл өөрийн бие дээр)

Хүний нөөцийг хөгжүүлэх гарын авлага боловсруулах, шинээр ажилд орсон хүнийг анхнаас нь сургах дасан зохицох хөтөлбөр боловсруулахаар төлөвлөж байна. Мөн “Тоёота” компанийн,

аливаа мүдэг арилгасныг, “Танака Тек” компанийн 3S-г хэрэгжүүлснийг өөрийн компанидаа хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

7. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Сурсан, мэдсэн зүйлсээ **Just in time** зарчмаар хэрэгжүүл. Тодруулбал,

- Цаг алдалгүй тэмдэглэж ав.
- Цаг алдалгүй хэрэгжүүлж эхэл.
- Боломжтой зүйлсээсээ бага гэхгүй өөрчилж эхэл.

3S хэрэгжүүлсэн жишээ /Мишээл салбар дэлгүүр дээр/



1. Дэлгүүрийн зааланд байгаа жижиг симплд хувийн эд зүйл буюу хумсны будаг хийсэн байсныг сануулж хэлсэнийг зассан байгаа нь 🍌❤️🍌

Like

Comment



2. Зааланд байдаг зочны ширээн дээрх зүйлс эмх замбараагүй, коридорын цонхоор хүн бүхэнд харагдахуйц хэсэгт хоолны таваг тавьсан байсныг сануулахад бүр байрлалыг нь хүртэл өөрчлөөд янзалчихсан чадалтай бүсгүй 🍌🍌🍌🍌

Like

Comment



3. Засварын үлдэгдэл материал, худалдаанд хараахан гаргаагүй бараа бүтээгдэхүүн ууттай хогтой холилдон заалны баруун хойд хэсэгт 3 сарын турш овоорсон байсныг ингэж цэвэрлэж цэгцэлжээ. 🍌🍌🍌🍌🍌🍌

Like

Comment



4. Шалаар нэг хэвтүүлж тарааж орхисон тагнуудыг нэг буланд цэгцтэй хураав. 🍌🍌🍌

Like

Comment




5. 8 сарын сүүлээр шинээр байрлуулсан энэ ваннад силиконыг нь хаттал түр ивсэн хөөс 2 сар гаруйн хугацаанд тэр хэвээрээ байж, манай компанийг хэтэрхий болхи, хэтэрхий арчаагүй харагдуулж байсныг авч цэвэрлэжээ. Баярлалаа 🍌🍌🍌🍌🍌🍌

Like

Comment

“ГОЁО” ХХК

Нэр: **Г.Гэрэлмаа**
 Албан тушаал: **Хүний нөөцийн менежер**
 Үндсэн сургалт төгссөн он: **2018**



Компанийн нэр:	Гоёо ХХК
Байгуулагдсан он:	1993
Үйл ажиллагааны чиглэл:	Ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдаа Тэмээний ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдаа
Ажилчдын тоо:	817

Компанийн товч танилцуулга

1993 онд Монголын анхны хувийн хэвшлийн ноос, ноолуурын компани болж 50 ажилтантай байгуулагдсан. Бэлчээрийн мал аж ахуйн үнэт баялаг болох ноос, ноолуурыг боловсруулж ээрмэл утас хийхээс эхлээд эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж дотоод, гадаадын зах зээлд борлуулах хүртэлх бүхий л үйл ажиллагааг бид өөрсдөө эрхлэн явуулдаг бөгөөд эдүгээ манай үйлдвэр Гоёо брэндээс гадна Европ, Азийн зах зээлд танигдсан брэнд бүтээгдэхүүнүүдийг захиалгаар үйлдвэрлэж байна.

2017 оны 12 сараас “ТАВАН БОГД ГРУПП”-ийн охин компани болон өмчлөл шилжсэнээр менежмент болон бодлогын түвшинд томоохон өөрчлөлтүүд хийгдэж байна. Тухайлбал бид 2018 оноос үйлдвэрлэлийг бүрэн хүчин чадлаар нь ашиглаж, ноолууран бүтээгдэхүүний нэр төрөл, өрсөлдөх чадварыг сайжруулах, гадаад, дотоодын зах зээлийг өргөжүүлэх зорилгын хүрээнд үйлдвэрлэлийн хүчин чадал, бүтээмжийг үе шаттайгаар нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжийн шинэчлэлд хөрөнгө оруулалт хийж, ажлын байрыг нэмэгдүүлэн ажиллаж байна.



1. Монгол-Японы төвийн Бизнесийн Үндсэн сургалтад суух болсон шалтгаан

1. Үйлдвэрийн байгууллагуудын сургалтын бодлого, арга аргачлал
2. Тогтвортой ажиллахад нөлөөлөх япон маягийн менежмент
3. Экспорт хийх боломж, Япон харилцагчийн тоог нэмэгдүүлэх

2. Бизнесийн үндсэн сургалтад сурсан зүйлээ компанидаа яаж хэрэгжүүлж байна вэ? Компанид гарсан өөрчлөлт

Шинэ ажилтны чиглүүлэх сургалт

Шинэ ажилтнуудын бүтэн өдрийн сургалтыг 11 сараас эхлэн 7 хоног бүр хийж хэвшиж байна. Уг сургалт нь баасан гараг бүрт шинээр орсон ажилтнуудад компанийн үйл ажиллагаа, процесс, дотоод журам болон шаардлагатай мэдээллийг нэг дор хүргэх, үйлдвэрийг танилцуулах, Гоёо брэндээрээ бахархах сэтгэгдлийг төрүүлэх зорилготой.

Япон маягийн менежмент

Японоос сурч мэдсэн зүйлсээ “Таван Богд Интернэйшнл” ХХК-ийн борлуулалт, удирдлагын баг болон Гоёо компанийн ажилтнуудтай хуваалцаж хэрэгжүүлж болохуйц санаа өгсөн.

Ажилтнуудын сэтгэл ханамжийг дээшлүүлэх

Оффис болон үйлдвэрийн ажилтнууд 7 хоногт 2 удаа спорт зааланд тоглож, иогийн хичээлд хамрагдах боломжтой болсон.

Экспорт

Бизнес уулзалтаар танилцсан Японы Marufuku Co.,Ltd компанид \$1261.5 бүтээгдэхүүний дээж явуулж хамтын ажиллагаагаа эхлүүлээд байна.

3. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл

- Токио, Осока хотуудад 2 удаагийн бизнес уулзалтанд оролцож боломжтой 2 харилцагчтай дэлгэрэнгүй мэдээллээ өгсөн.
- Өөрчлөлтийн менежмент: Борлуулалтын орлого, ашиг буурах, нийгэм соёл, зах зээлийн бүтцийн томоохон өөрчлөлттэй үеүдэд удирдлага хүн бүтээгдэхүүн үйлчилгээ, менежментийн арга барил, тоног төхөөрөмж зэргийг ухаалгаар өөрчилж байх
- Сургалт:
 - “Рело Панасоник эксэл интернэйшнл” компаниас ажилтнуудыг сургах, нарийн мэргэжилтэй инженер техникийн ажилтнууд бэлтгэж өрсөлдөөнд давуу тал олох, залгамж халаа бэлтгэхийн тулд дотооддоо сургагч багш, хөтөлбөр, сурах бичиг гарын авлага, анги танхимыг системтэйгээр бэлтгэх боломжтой болох
 - “Микки хаус”, “АР” компаниудаас шинэ ажилтны чиглүүлэх сургалтанд маш их анхаардаг болох
- Япон маягийн менежмент:
 - Хоожоо багшийн лекц, “Гогёофүкү” болон бусад очиж танилцсан компаниудаас ажилтан, түүний гэр бүл компанийн хамгийн үнэт зүйл болохыг ойлгосон
 - Компани үүсгэн байгуулагдсан түүх, бүтээгдэхүүн үйлчилгээ бий болсон түүх, үүсгэн байгуулагчийн философи түүний үе хойч хадгалан, нийт ажилтнуудад танилцуулах нь компаниараа бахархах, мөн чанарыг ойлгоход тустай гэдгийг мэдэж авлаа.
 - Кэйзен, 5S
- Цалин, урамшууллын систем: “Гогёофүкү” компанийн цалин, урамшууллын систем нь ажилтан хэдий хэмжээний урамшуулал, цалин авах, цалингаа хэр хэмжээгээх өсгөх зэргийг өөрөө тооцоолох боломжтой байлаа.
- Ажилтан сэтгэл ханамжтай ажлаа хийвэл түүний хийж байгаа ажил үйлчилгээ чанартай, бүтээмжтэй байдаг. Улмаар чанар бүтээгдэхүүн үйлчилгээ авснаар хэрэглэгч харилцагч сэтгэл ханамжтай байж, компани ашигтай ажиллана. Компани орлого ашигтай байснаар нийгэм болон ажилтнууд, түншүүддээ хөрөнгө оруулж чадна гэдгийг ойлгосон.

Хэрэглэгчийн сэтгэл ханамж = Ажилчдын сэтгэл ханамж



4. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

Газар дээрх баялаг бага, газар нутгийн хэмжээ багатай арал улс яагаад ийм өндөр хөгжилтэй байгаагийн гол нууц нь хүнээ дээдэлсэн менежментийг явуулсанд байгаа гэдгийг ойлголоо. Иймд компани, улс орон хүнийхээ хөгжил дэвшилд анхаарахын сацуу ухамсар хандлагыг зөв болгохыг хичээж ажиллах нь зөв юм байна. Манай компани сургалт, хөгжлийн бодлогодоо энэ бүхнийг тусган ажиллаж байна.


5. Сургалтын талаарх сэтгэгдэл, компани хэрэгжүүлж болохуйц жишээ

Монгол- Японы төв болон “Рело Панасоник Интернэйшнл” компаниуд сургалтын бэлтгэл ажлыг маш сайн зохион байгуулсан тул сургалтын явцад ямар нэгэн асуудал үүсээгүй, сургалт амжилттай өндөрлөсөн. Энд сурч мэдсэн зүйлээ бодит байдал дээр нүдээр үзэж, япон соёл, менежментийг ойлгож суралцсандаа маш их баяртай байгаа.

Одоогоор үйлдвэрийн өргөжилт, засварын ажлууд дуусаагүй байгаа тул ирэх оноос 3S-ийг хэрэгжүүлж болохуйц санагдсан. Мөн сургалтын анги танхимтай болж цаашид тогтмол, системтэйгээр сургалт зохион байгуулдаг болно.

6. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани эсвэл өөрийн бие дээр)

1. Өөрийн компанийн өрсөлдөх чадварт суурилан 2019 онд ур чадварын үнэлгээний журмыг боловсруулан нийт ажилтнуудын чадамжийг тодорхойлно. Группийн жишиг журмыг үндэслэн мэргэжлийн ур чадварыг илрүүлэх арга аргачлалыг шууд удирдлага болон мэргэжлийн багтай хамтран тодорхойлно.



ҮЗЭЛ ХАНДЛАГА * ГАЛ ЭРМЭЛЗЭЛ * ЧАДВАР = ҮР ДҮН



2. “Таван Богд” группийн сургагч багшийн хувьд 3S сургалтыг өөрийн болгож сургалтын модулийг бэлтгэн сургалт орно.

7. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Дадлага сургалтаас олж авсан мэдлэг мэдээллээ ирсэн даруйдаа компанийн хамт олонтойгоо хуваалцаж тэдэнд маш сайн ойлгуулах нь чухал. Тэдний санаа бодлыг сонсож хэрэгжүүлж болохуйц туршлагыг нэвтрүүлэх ажлыг хамтран хийх нь илүү үр дүнтэй. Өөрөө явсан бол Үндсэн сургалтад хамт сурсан ангийнхнаа хамруулж вектороо ижилсүүлээрэй.

Японд байх хугацаандаа аль болох үр бүтээлтэй байж япон соёл, өв уламжлалтай танилцсаж тэдний менежментийг ойлгохыг хичээгээрэй.

“БАЯН ТҮМЭН КОНСАЛТИНГ” ХХК

Нэр: **Н. Батчулуун**
Албан тушаал: **Гүйцэтгэх захирал**
Үндсэн сургалт төгссөн он: **2018 оны үндэсний сургагч багш, менежментийн зөвлөх бэлтгэх сургалт**








Компанийн нэр:	Баян түмэн консалтинг ХХК
Байгуулагдсан он:	2016
Үйл ажиллагааны чиглэл:	Менежментийн зөвлөх үйлчилгээ
Ажилчдын тоо:	1

Компанийн товч танилцуулга

Баян Түмэн Консалтинг ХХК нь менежментийн зөвлөх үйлчилгээний бизнес эрхэлдэг ба дэлхийн шилдэг менежментийн арга барил, туршлагыг монголын байгууллага, компани, хувь хүмүүст таниулах, тэднийг сургалт болон зөвлөгөө үйлчилгээгээр дамжуулан хөгжүүлэх зорилготой билээ.

Сургалт, зөвлөгөө үйлчилгээний үндсэн чиглэл нь Тоёотагийн үйлдвэрийн удирдлагын тогтолцоо, Манлайллын ур чадвар, бизнес сайжруулалтын арга барил, аюулгүй ажиллагаа зэрэг чиглэлээр эрчим хүч, уул уурхай, хүнс хөдөө аж ахуй, эмнэлэг, боловсрол гээд бүх салбарт чиглэсэн, компанийнхаа үйл ажиллагааг сайжруулах, мэдлэг ур чадвараа улам дээшлүүлэх хүсэлтэй удирдлага, ажилтанд сургалт, зөвлөгөөг өгөх юм.

<p style="background-color: red; color: white; padding: 5px;">Тоёотагийн үйлдвэрлэлийн удирдлага</p>  <p style="background-color: #cccccc; padding: 5px;">Засварын нэгдсэн удирдлага Чанарын нэгдсэн удирдлага....</p>	<p style="background-color: red; color: white; padding: 5px;">Манлайлал ба байгууллагын соёл</p>  <p style="background-color: #cccccc; padding: 5px;">Манлайллын дадал, зуршил Байгууллагын үнэт зүйлс....</p>	<p style="background-color: blue; color: white; padding: 5px;">Бизнес сайжруулалт, бизнес шинэчлэлт</p>  <p style="background-color: #cccccc; padding: 5px;">Бизнес сайжруулалтын төсөл, санаачлага Хурлыг үр дүнтэй явуулах арга....</p>	<p style="background-color: yellow; padding: 5px;">ХЭМАБ-ын удирдлагын тогтолцоо</p>  <p style="background-color: #cccccc; padding: 5px;">Аюулгүй ажиллагааны соёл Эрсдлийн удирдлага....</p>	<p style="background-color: #003366; color: white; padding: 5px;">Хөрөнгийн удирдлага</p>  <p style="background-color: #cccccc; padding: 5px;">Хөрөнгийн ашиглалт, засварын удирдлага Үйлдвэрийн бүрэн ба түр зогсолт....</p>
----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

1. Монгол-Японы төвийн Үндэсний сургагч багш, менежментийн зөвлөх хөтөлбөрт хамрагдах болсон шалтгаан

Монгол орон зах зээлийн шинэ тогтолцоонд шилжсэнээс хойш хувиараа бизнес эрхлэх сонирхолтой хүмүүс нэмэгдэж, тэдгээр хүмүүсийн хувьд бизнесээ зөв удирдах, хүмүүсийг удирдахад асуудал байнга тулгарч байгааг, мөн тэд өөрсдийн мэдлэг чадвараа дээшлүүлэх, бусдаас суралцах ялангуяа Монгол-Японы төвөөр дамжуулах япон менежмент, япон багш нарын лекцэнд суух сонирхол өндөр байгааг харсан.

Монголд хэрэгжүүлж буй монголын бизнес эрхлэгчдийг дэмжих, тэдний мэдлэг ур чадварыг дээшлүүлэх төсөл цаг хугацаатай бөгөөд энэ хугацаандаа үндэсний сургагч багш, зөвлөх бэлдэж тэдгээр хүмүүсээрээ дамжуулан бизнес эрхлэгч нарт зөвлөгөө сургалтыг өгдөг байх хэтийн зорилгын хүрээнд үйлдвэрлэлийн удирдлага, чанарын удирдлагын чиглэлээр хүн хайж, түүнд хамрагдаж чадсан нь аз завшаантай тохиолдол болсон.


Энэхүү 2 жилийн хөтөлбөрийн сүүлийн шатны япон дахь дадлага сургалтад хамрагдаж, япон компаниудаар үйлдвэрлэлийн аялал хийн, туршлага судалж, мэдлэгээ зузаатгаж байгаадаа их баяртай байна.

2. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл

Компанийн үзэл баримтлал

“Тоёота” компанийг дэлхийн хэмжээний хөгжилд хүргэсэн гол нууц нь хүний хөгжлийг дэмжсэн удирдлагын зөв арга барилыг хэрэгжүүлсэн, мөн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хамгийн оновчтой болгож чадсан тогтолцоонд оршдог хэмээн үздэг. Гэхдээ үүнийг хэрэгжүүлэхэд компанийн үүсгэн байгуулагч, удирдагчын үзэл баримтлал, хандлага, оролцоо ба дэмжлэг нэн чухал. Ийм ч учраас “Тоёота”-гийн боловсон хүчний бодлого, ажилтнаа хэрхэн сургаж, хөгжүүлдэг тухай судалгааны баримт бичигт “Удирдагч хүний хандлага, сэтгэл, хүсэл тэмүүлээс ажлын байр өөрчлөгдөнө” гэж дурдсан байдаг.

Тоёода Сакичигийн баримтлах зарчим





- Удирдлага болон ажилтан бүгд нэгэн хүсэл зорилготой байж, үйлдвэрлэгч улс болохын төлөө хичээн зүтгэх
- Судалгаа болон шинэ бүтээлд сэтгэл зүрхээ зориулж, үргэлжид цагийн жамын дагуу урагш тэмүүлэх.
- Аливааг хөнгөн хийсвэр бус, практик бодит байдал талаас нь авч үзэх.
- Үргэлжид гэр бүлийн уур амьсгал мэт халуун дулаан сэтгэл, хамтын нөхөрлөлийг бүрдүүлэх
- Бурхан, байгаль эх дэлхийг хүндэтгэж, ач тус болоод талархлыг үргэлжид санаж явах

Тоёота компанитай адил Японы бусад жижиг компаниуд ч мөн адил үүсгэн байгуулагчид, компани удирдаж буй хүмүүс нь өөрсдийн үзэл баримтлал, юу хүсч мөрөөддөг, ямар байхыг хүсч буйгаа бичээд жаазлан, хурлын самбар, ажлын өрөөндөө байрлуулсан, түүнийгээ ажилчдадаа ярьдаг, хуваалцдаг байна. Доорх зурагт мөн бидний зочилсон хоёр компанийн үзэл баримтлалыг жишээ болгон оруулав.

Токиогийн хуванцар сав дахин боловсруулах үйлдвэр

Санпак ХХК



Түүхийг бүтээгчид, улс орныхоо төлөө зүтгэгсэд

Дэлхийн хэмжээний том, нэртэй компаниудын музейг үзэж, үүсгэн байгуулагдсан түүхтэй танилцаж байхад тэд зөвхөн өөрсдийн компанийн төлөө, ашиг олохын төлөө бус улс орноо хэрхэн хөгжүүлэх вэ, хэрхэн үйлдвэрлэгч улс болох вэ, яавал улс нийгмийнхээ төлөө сайн сайхан зүйл хийж болох вэ гэдэг сэтгэлээр ажиллаж байсныг харж болно.

“Панасоник” корпорацийг үүсгэн байгуулагч Коносүкэ Мацүшита Япон улсад цахилгааны эрин үе ирж байгааг мэдэрч, ирээдүйд айл өрх бүр цахилгаан бараа бүтээгдэхүүн хэрэглэдэг, тэр нь хүн ардын аж амьдралыг тэтгэдэг байх ёстой гэж үзэж байсан. Мөн компани нь хөл дээрээ босч бизнес нь өсөж дэвжсэн ч, улс орныг удирдаж буй удирдагчид нь сурч боловсроогүй бол Япон улс хөгжихгүй хэмээн үзэж компанийнхаа хажууд РНР институт байгуулж, улс төрчид, парламентийн гишүүдийг үнэ төлбөргүй сургалтанд хамруулж, өөрөө лекц уншдаг байсан нь Япон улсыг зөв бодолтой хүмүүс удирдан чиглүүлэхэд хувь нэмэр болсон гэдэг.



“Панасоник” корпорацийг үүсгэн байгуулагчийн музей



“Кавасаки” корпорацийг үүсгэн байгуулагчийн музей

“Кавасаки Индустри” компанийг бид мотоцикл үйлдвэрлэдэг гэдгээр нь мэднэ. Гэвч нийгэмд зориулсан техник технологи, аж үйлдвэрийн зориулалттай маш олон төрлийн, том цар хүрээтэй, хүнд машин техник үйлдвэрлэдэг гэдгийг цөөн хүн мэдэх байх. Ачааны ба зорчигчдын усан онгоц, хурдны болон ердийн галт тэрэг, пуужин, газар доорх туннел ухаг өрөм, үйлдвэрийн зориулалтай робот, аж үйлдвэрийн том барилга, тоног төхөөрөмж гээд маш олон төрлийн нийгмийн үйлчилгээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болохыг Кавасакигийн музейг хараад ойлгоно.

3. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

Миний хувьд япон улсад суралцаж, амьдарч байсан, “Мицүбиши”-гийн электроникийн үйлдвэр болон бусад компанид ажиллаж байсан тул япон соёл, япон хүмүүсийн хүндэтгэл, хариуцлага хүлээх ухамсрын талаар тодорхой хэмжээгээр ойлгох ч, энэ удаагийн сургалтаар “Тоёота”-гийн

компанийн үйлдвэрээр орсноо маш их аз завшаан, боломж олдсон гэж бодож байна. Удаан хугацаанд очихгүй байж байгаад дахин очсон нь нүдийг минь дахин нээж өгч чадсан.

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга



Баян Түмэн

Менежментийн зөвлөл үйлчилгээ

ТОЁОТАГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Дэлхийн шилдэг менежментийн арга, туршлага

Бизнесийн үйл ажиллагааг үр ашигтай, бүтээмжтэй, бүтээгдэхүүн үйлчилгээг чанартай хүргэхэд туслана. Дэлхийн шилдэг компаниуд бүгд Тоёотагийн үйлдвэрлэлийн удирдлага буюу Лийн зарчмаас үргэлжид суралцдаг.

- Тоёотагийн үйлдвэрлэлийн удирдлага ба Япон менежмент
- Жидока
- Жаст ин тайм
- Кайзен
- Чанарын удирдлага
- Засвар үйлчилгээний нэгдсэн удирдлага



Баян Түмэн

Менежментийн зөвлөл үйлчилгээ

зөвлөгөө хэлбэрээр Монгол компаниудын удирдлага, ажилтнуудад хүргэхийг хүсч байна.

БАЙГУУЛЛАГУУДЫН БОЛОВСОН ХҮЧНИЙ ЧАДАВХЫГ ХӨГЖҮҮЛЭХ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ СУРГАЛТ, ЗӨВЛӨГӨӨ ҮЙЛЧИЛГЭЭ

МАНЛАЙЛАЛ БА БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ



Байгууллагын бүх түвшинд манлайлагчид бий болох боломжтой. Тэд компанийнхаа эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлсийг ухамсарлан, үлгэр жишээч байж, хамт олныг чиглүүлэх, компанийг хөгжил дэвшилд хүргэх, байгууллагын соёлыг бий болгоход туслана.

- Өөрийгөө болон бусдыг удирдахуй
- Манлайлын дадал, үлгэр жишээ манлайлын хэв маяг
- Хариуцлага, үүрэг даах чадвар
- Заварчлах арга, удирдлагууд ажилын талбарт хөтөлбөр
- Зорилгоор удирдах
- Байгууллагын соёл
- Тоёотагийн хүнээ хөгжүүлэх арга

7. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Их зохиолч Д.Нацагдоржийн зохиолд “Хээрийн галуу нисэх үл хүрэх газраас хүний хүү эрдэм өвөрлөн ирнэ” гэж бичсэн байдаг, Монгол залуучууд Япон орноос зөвхөн технологи, материаллаг эдийг бус, тэдний үйлдвэрлэл эрхлэх арга ухаан, удирдагчдын үзэл баримтлал, хандлага, хариуцлага хүлээх чадвар зэргийг сонсож харж, суралцаасай гэж хүсч байна. Япон улс өөрөө АНУ, Европоос суралцсан, харин Солонгос, Хятад улсууд Японоос суралцаж өдий хэмжээний хөгжлийн түвшинд хүрсэн. Харин Монголчууд бид аль алинаас суралцаж, нийгмээ сайн сайхан болгохын төлөө бүгд хичээн зүтгэх ёстой хэмээн итгэж байна.

“АСЫЛМУРА” ХХК

Нэр: А. Гүлмайра
Албан тушаал: Захирал
Үндсэн сургалт төгссөн он: 2018



Компанийн нэр:	Асылмура ХХК
Байгуулагдсан он:	2007
Үйл ажиллагааны чиглэл:	Хатгамал
Ажилчдын тоо:	60

Компанийн товч танилцуулга

“Асылмура” ХХК нь анх 2007 оны 11 сард байгуулагдаж, 2008 оны 6 сард үйл ажиллагаагаа 13 хүний бүрэлдэхүүнтэй эхлүүлж байсан. Одоогоор манай компаний нийт ажилчдын тоо 60-с дээш хүний бүрэлдэхүүнтэй болж өргөжин үйл ажиллагаагаа явуулсаар байна. Манай компани нь Улаанбаатар хотын хажууд байрладаг. Налайх дүүрэг болон нийслэлээс 1600 км хол зайд байдаг Баян-Өлгий аймагт үйл ажиллагаагаа явуулж байна. Монгол улсын баруун хязгаарт оршдог Баян-Өлгий аймагт үндэстний буюу 100 гаруй мянган Казах иргэд амьдардаг.

Дэлхийн олон оронд казах үндэстэн амьдардаг бөгөөд тэдний соёл хэдий ижилхэн боловч, өвөг дээдсээс уламжлагдан ирсэн гар хатгамалыг гараар хийхээс илүүтэй машинаар хийж хэрэглэдэг бол бид хээ хуараа гараар хатгахыг илүүд үздэг. Энэ бидний давуу тал байгаад зогсохгүй гараар хатгамал хийх нь байгаль, нийгэм, соёл, хувь хүний төлөвшилд сайнаар нөлөөлдөг тул илүү үнэ цэнийг бий болгож байдаг.

Одоогоор манай байгууллага Налайх дүүрэг болон хөдөө орон нутагт нас, боловсрол харгалзахгүйгээр ажил хийх хүсэлтэй эмэгтэйчүүдийн ажлын байрны нөхцлийг сайжруулах, дэргэдээ цэцэрлэг, сургуулийн хүүхдийн өдөр өнжүүлэх төвтэй, хатгамалчидаа байнга сургах боломжтой сайхан ажлын байрыг бий болгохыг зорьж, хэрэглэгчдийн хүсэлд нийцсэн бүтээгдэхүүнээ байнга сайжруулан ажиллаж байна.

1. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл

Япон руу явахаас өмнө - Японд очиж яг юу сурахыг хүсэж байна?- гэдэг асуултанд олон төрлийн асуудлын шийдлийг олох тухай бичиж байсан ч хамгийн чухал нь ажил олгогч болон ажилчдын хандлагын ялгааг олж харах, түүний бизнес дэх нөлөөллийг харах байсан.

2. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

Би Японд анх удаа очсон бөгөөд миний бодсоноос арай өөр бөгөөд бүх юм маш энгийн байгаа нь миний сонирхлыг ихэд татсан. Би болон манай багийнхан алхам бүрт суралцаж байсан. Нүдэнд

харагдаж буйгаар хэлэхэд маш цэвэр, эмх цэгцтэй гудамжийг тусгайлан маш сайн шётка-аар үрж угаадаг юм шиг цэвэрхэн байсан. Жайка-Токио, Жайка-Кансайн байрнууд хүний хэрэгцээ, мөн зорилгын хүрээнд хэрхэн ажилладгийг харуулсан тод томруун жишээ байсан.

3. Сургалтын талаарх сэтгэгдэл, компани хэрэгжүүлж болохуйц жишээ

Ямар ч үйлчилгээний газарт яваад очиход эелдэгээр инээмсэглэн мэндэлж, эелдэг хандаж байсан. Мэдээж хамгийн сайхан хэсэг нь бидний ижил бизнесийн үйл ажиллагаа явуулдаг үйлдвэр үйлчилгээний газруудаар зочилж, туршлага судлах байлаа.

- Дэлхийн тэргүүлэгч TOYOTA
- Танака тех. Төмөр төхөөрөмжийн захиалгын үйлдвэр
- Эмнэлэгийн нарийн тоног төхөөрөмж 0.1 микроны хэмжээтэй сэлбэг 3D, 4D бүтээгдэхүүний үйлдвэр
- Хувцасны үйлдвэр
- Рестораны сүлжээ
- Попкорны үйлдвэр
- Дугтуйны үйлдвэр
- Хог боловсруулах үйлдвэр
- Панасоникийн музей гэх мэт газруудаар зочлох болгонд ихийг суралцаж маш их сэтгэл догдолж байсан.

Энэхүү үйлдвэр үйлчилгээний газрууд өөр өөрсдийн онцлогтой байсан хэдий ч “Нийгэмд хэрэгтэй компани болох

Нийгэмд хэрэгтэй хүн бэлдэх” гэх мэт нийтлэг шинж ажиглагдсан.

Миний сурахыг харахыг хүсэж байсан хандлагын ялгаа энд харагдсан бөгөөд энэхүү үзэл баримтлал нь алсын хараатай нэгдэж маш их холыг харсан, бүх үйл ажиллагаагаа хүний сайн сайхны төлөө чиглүүлсэн нийгмийн сайн сайхныг илүүд үзсэн нь ирээдүй болон өнгөрсөн үйл ажиллагаанаас нь харагдаж байсан.

Панасоникийн музейд очиж 1917 оноос хойшхи үйл ажиллагаатай нь танилцаж байхдаа К.Мацүшитагийн хүн, хамт олон, эх орон, эх дэлхийгээ гэсэн хайр, алсын хараа нь миний алсын харааны тухай ойлголтыг бүрэн эвдсэн бөгөөд энэ нь миний амьдралдаа олж авсан хамгийн том ололт юм шиг санагдаж, баярлаж бас маш их гайхсан.



Time Capsule буюу ирээдүйд илгээх захидал гэсэн энэхүү тогоог 1970 оны WORLD EXPO-д зориулж, “Панасоник”-ийн 1917 оноос хойш үйлдвэрлэж байсан брэнд бүтээгдэхүүнүүдээс хийгээд чанартай гэгч нь тагласан байсан. Яг ийм адилхан 2 тогоог Осака хотын Химэжи цайзын үүд хэсэгт эхний тогоог 5 метрийн гүнд, 2 дахь тогоог 9 метрийн гүнд тус тус булж, 5 метрийн гүнд байгаа тогоог 2100 онд нээж үзэх, 9 метрийн гүнд байгаа тогоог 6970 он буюу 1970 оноос хойш 5000 жилийн дараа нээж үзэх тухай тайлбар бичсэн байсан.

Панасоникийг үүсгэн байгуулагч Мацүшита Коносүкэ хэмээх энэ эрхэм хүний эх орон, хойч үе, эх дэлхийгээ гэсэн үзэл санаа нь цаг хугацаанд баригдаагүй, алсын хараанд нь хязгаар байхгүй байгаа нь үгээр хэлэхийн аргагүй бахархам сэтгэгдэл төрүүлсэн бөгөөд миний сурахыг хүссэн зүйлийг утгаар нь харуулсан.

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани эсвэл өөрийн бие дээр)

Энэхүү алсын харааны тухай ойлголт миний болон одоогийн бидний эх орны бүх сул тал, бүх асуудлын үндэс юм байна гэсэн бодлыг яах аргагүй төрүүлж байсан.

Алсын хараа үзэл баримтлал гээд бүхий л зүйл хүний төлөө болоод тэр нь хүнийг урт хугацаанд сайн сайхан амьдрах орчин, нийгмийн төлөө байсныг илүү сайн ойлгосон. Үүнийг олж харснаар мөнгө олох нь чухал биш гэдгийг дуртайяа хүлээн зөвшөөрч

- Үйл ажиллагаагаа 30 жилээр төлөвлөх,
- Ажилтан хэрэглэгчийг зөв ойлгож, тэдний урт хугацааны сайн сайхны төлөө бүх үйл ажиллагаагаа чиглүүлэх
- Манай компанийн асуудал манай компанийн дотор байгаа тул асуудалд илүү хүндэтгэлтэй зөв хандах
- Алсын харааны хүрээнд ажиллах
- Хүнийг ойлгох, хүнийг хайрлахад илүү анхаарах
- Шалтгааныг эрж олох гээд ажлуудыг тасралтгүй сайжруулж хийх.

Тасралтгүй идэвхтэй ажиллаж, байнга сайжирдаг. Хүний сайн сайхны төлөөх менежментийг үндэс суурь болохыг ухаарч түүнийгээ хэрэгжүүлж эхэлсэн.

Тасралтгүй сайжрах зорилгын хүрээнд ажиллахдаа

- Эх орондоо хэрэгтэй компани болох,
- Аз жаргалтай зөв бодолтой, зөв үйлдэлтэй иргэн төлөвшүүлэхэд хөрөнгө оруулж,
- Соёлоо хэрэглэгчдэд зөв таниулж, хэрэглэгчийн хүслийг ойлгож ажиллахад анхаарна.

“АВТОСОС” ХХК

Нэр: **П.Ганзориг**
Албан тушаал: **ТУЗ-ын дарга**
Үндсэн сургалт төгссөн он: **2018 оны загвар аж ахуй нэгж**



Компанийн нэр:	АвтоСОС ХХК
Байгуулагдсан он:	2012
Үйл ажиллагааны чиглэл:	Даатгалын нэгдсэн шуурхай албаны үйлчилгээ
Ажилчдын тоо:	25

Компанийн товч танилцуулга

- 2012 онд Даатгалын компаниудын шуурхай албаны үйлчилгээг аутсорсингоор үзүүлэх зорилгоор байгуулагдан 7 дахь жилдээ амжилттай үйл ажиллагаа явуулж байна.
- 25 ажилтан, 6 автомашин, 3 сүтэртэй. 7 хоногийн 24 цагаар ажилладаг.
- 2018 оны байдлаар 11 даатгалын компанид буюу зах зээлийн 60% орчимд шуурхай албаны үйлчилгээг аутсорсингоор үзүүлэн ажилладаг.
- 1 жилд 25-30 мянга дуудлага хүлээн авч ослын газарт шуурхай очиж даатгуулагчид зөвлөгөө мэдээлэл өгч, 50-60 мянган автомашины ослын мэдээллийг бүртгэж даатгалын компаниудад шууд хүргэдэг.
- Ослын дуудлагын мэдээллийг хүлээн авах, бүртгэх, дамжуулах, хянах зэрэг бүх үйл ажиллагааны процесс програмчлагдсан.

АЛСЫН ХАРАА

Монгол улсын бизнесийн очинд өндөр ёс зүй, нийгмийн хариуцлагын өндөр жишиг тогтоосон, үнэ цэнийг бүтээгч шилдэг менежменттэй компани болно.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Технологийн хөгжил дэвшлийг ашиглан, олон улсын жишигт нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэгчдэдээ хүргэнэ.

ҮНЭТ ЗҮЙЛС, ЗАРЧИМ:

- Өөриймсөг үзэл - Компани ажилтнууд, нийгэм, байгаль орчиндоо, Ажилтнууд хамт олон, харилцагчдадаа үргэлж өөриймсөг сэтгэл, өндөр хариуцлагаар хандана.
- Өндөр бүтээмж - Бид тасралтгүй суралцан хөгжиж, мэргэжлийн өндөр ур чадвар, чадамжтайгаар шинийг санаачлан үргэлж үнэ цэнэ бүтээнэ.
- Тогтвортой хөгжил - Бид багийн ажиллагаа, амжилтыг эрхэмлэн, институцийн зөв тогтолцоо, засаглалын зарчмыг баримтлан урт хугацааны тогтвортой хөгжлийг бий болгоно.

Компанийн оролцогч талуудад үүсгэж буй үр ашиг, үнэ цэнэ:

▪ Харилцагчид буюу даатгалын компаниуд, даатгуулагчдад:

- Даатгалын компаниудын шуурхай албаны зардлыг 40-өөс 90 хүртэл хувиар хэмнэдэг
- Ослын газарт түргэн шуурхай очдог, хүчин чадлын хүртээмжтэй байдал сайн (осол ихээр гардаг хар цэгүүдтэй ойр байрлаж, автомашин скүтрийг хослуулан ашигладаг)
- Үйлчилгээний өндөр стандарт (мэдлэгийн болон харилцааны чадварын сургалтад тогтмол хамруулдаг)
- Маш сайн хяналтын тогтолцоотой (хуурамч даатгалын тохиолдол үүсгэх эрсдэлийг хааж, хянадаг тогтолцоо бүхий технологийн шийдэлтэй)

▪ Хувьцаа эзэмшигчид, ажилтнуудад:

- Зах зээлд (Даатгагч болон Даатгуудагчид) хэрэгтэй, чухал үйлчилгээг үзүүлдэг
- Тогтвортой ажлын байр бий болгож, улс орондоо татвар төлж, нийгэмдээ хувь нэмрээ оруулдаг.
- Ажилтнуудыг сурч хөгжих боломжоор хангаж, эрүүл аюулгүй орчинд ажиллуулдаг
- Хуримтлуулсан дата мэдээллээ ашиглаж, зам тээврийн ослын шалтгааныг нарийвчлан тодорхойлж, түүнийг буруулах чиглэлээр холбогдох байгууллагуудад шийдэл санал болгодог.
- Нэгдсэн шуурхай албаны үйчилгээгээр мэргэшиж, туршлагжсан цорын ганц компани.

1. Монгол-Японы төвийн ЗААН-ийг хөгжүүлэх хөтөлбөрийн сургалтад суух болсон шалтгаан

1. Япон менежментийн хүн төвтэй арга барилаас суралцаж компанийнхаа бодлого стратегид тусган хэрэгжүүлэх.
2. Үйлчилгээний соёл, стандарт өндөр хөгжсөн Япон арга барилаас суралцаж компанийнхаа үйл ажиллагаандаа нэвтрүүлэх замаар даатгалын компаниудын нөхөн төлбөрийн үйлчилгээг сайжруулах.

2. ЗААН-ийг хөгжүүлэх хөтөлбөрийн сургалтад сурсан зүйлээ компанидаа яаж хэрэгжүүлж байна вэ? Компанид гарсан өөрчлөлт

1. Чадамжийн загвараар хүний нөөцийн үнэлгээний системийг бий болгосон.

Компанийнхаа бүх албан тушаалуудын чадамжийн хүснэгтийг боловсруулан гаргаж ажлын байрны тодорхойлолт, сонгон шалгаруулалтын тогтолцоо, зэрэглэлийн тогтолцоо, үнэлгээний тогтолцоо, урамшууллын тогтолцоо зэрэгт ашиглан сонгон шалгаруулалтын үр дүн сайжирч, сургалт хөгжлийн бодлого оновчтой болж, ажилтнуудын гүйцэтгэлийг илүү бодитой үнэлдэг болсон.

Мөн бүх ажилтнууд компанийн философи, Vision/Mission-с эхлээд, хэлтэс нэгжийн зорилгыг тодорхойлж чаддаг, өөрийн хэлтэс нэгжийн зорилгоо биелүүлж чаддаг, давтамж их ажлуудыг илүү үр дүнтэйгээр өндөр бүтээмжтэй явуулахын тулд сайжруулалт хийдэг, өмнө нь байгаагүй, шинэ зүйл болон инноваци санаачилдаг, өөрийн залгамж болох хүнийг сургаж, хөгжүүлж залгамж халаагаа бэлддэг болоод байна.

Оператор болон дуудлагын мэргэжилтэн гэсэн 2 албан тушаал дээр боловсруулсан чадамжийн хүснэгтийг жишээг байдлаар оруулав.

Албан тушаал	Чадамж	Тайлбар	Агуулга /үндсэн шаардлага/	
			Дуудлагын мэргэжилтэн	Дуудлагын ахлах мэргэжилтэн
Дуудлагын мэргэжилтэн	Тайлбар		<ul style="list-style-type: none"> • Энгийн ажлыг, бусдын тусалцаа авалгүйгээр хийдэг. 	<ul style="list-style-type: none"> • Ямар нэг ажлыг хийж чадахгүй байгаа болон учир дутагдалтай байгаа хэсэгт нь зөв ажлын арга барилыг зааж өгөхийн сацуу асуусан асуултад нь хариулж чаддаг. • Шинэ зүйлд идэвхтэйгээр оролцдог.
	Үнэт зүйл	Компанийн үнэт зүйлийг мэддэг бөгөөд үүнд тохирсон үйл ажиллагааг явуулах	Компанийн философи, алсын хараа, эрхэм зорилгыг ойлгодог байх	<ul style="list-style-type: none"> • Өөрөө сайтар ойлгосны үндсэн дээр дагалдан ажилтанд өөрийн үйлдэл, заавраар дамжуулан ойлгуулж, компанийн үнэт зүйлд нийцсэн үйлдлийг хийлгэх • Компанийн нийгмийн хариуцлагыг ойлгож үүнд нийцсэн үйлдэл хийдэг байх.
	Үүрэг хариуцлага	Өөрийн үүрэг хариуцлагын хүрээг мэддэг, ойлгож үйлдэл хийдэг байх	Ослын дуудлага хүлээж авснаас хойш, даатгуулагчид нөхөн төлбөр олгогдох хүртэлх үйл ажиллагаа нь өөрийн хариуцлага гэдгийг мэддэг байх.	Өөрийн хариуцлагын хүрээг ойлгож, хэрэгжүүлж чаддаг байхаас гадна дагалдан ажилтанд үлгэр дуурайлал үзүүлэх.
	Ажил гүйцэтгэх чадвар	Үүрэг хариуцлагын хүрээнд хийх ажлын гүйцэтгэлийг хамгийн сайн байлгах	Ажлын байрны тодорхойлолтын дагуу ажлаа гүйцэтгэх	Ажлын үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэхийн тулд тасралтгүй арга хэмжээ авч байх <ul style="list-style-type: none"> • Компанийн дотоод, гадаад төрөл бүрийн нөөцүүдийг ашиглаж чаддаг байх.
	Мэдлэг	Ажлын гүйцэтгэлд хэрэгцээтэй бүх мэдлэгийг сурч, ажилдаа хэрэглэх	Хууль, дүрэм, журам, Даатгалын бүтээгдэхүүнүүд, Нөхөн төлбөрийн үйл ажиллагаа, Автомашин, Мэдээллийн технологи, Авто замын схемийн мэдлэг, Авто замын схем, хаягжилтийн мэдлэг өндөр байх, Хохирол үнэлгээний мэдлэгтэй байх, Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, Галын аюулгүй байдлын анхан шатны мэдлэгүүдийг эзэмшсэн байх.	Ослын нөхцөл байдал, онцгой тохиолдол зэргийг бүрэн эзэмшиж, гэнэтийн нөхцөл байдалд арга хэмжээ авч чаддаг байх.
	Шийдвэрлэх чадвар	Хууль, дүрэм журамд үндэслэн тохиромжтой шийдвэр гаргах	Хууль, дүрмийг мэддэг бөгөөд тогтсон шийдвэрлэх гарцыг мэддэг байх.	Онцгой тохиолдлуудын туршлага хуримтлуулан арга хэмжээ авч чаддаг байх, бусад дуудлагын мэргэжилтнүүдэд зааж сургадаг байх.
	Өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх тэмүүлэл	Өөрийгөө хөгжүүлж, компанийн хөгжилд хувь нэмрээ оруулмаар байна гэсэн тэмүүлэлтэй байхаас гадна, тэрийгээ үйлдэл болгодог байх.	<ul style="list-style-type: none"> • Дараа жилийн эзэмших ёстой мэдлэгээ ямар аргаар сурах вэ гэдгээ төлөвлөж, менежерээр дүгнүүлэх • Суралцахаа үргэлжлүүлж, тогтмол хугацаанд засаж, залруулж байх 	<ul style="list-style-type: none"> • Өөрийн туршлагаасаа дагалдан ажилтан, дуудлагын мэргэжилтнүүдэд зааж сургах, өөрийн сурсан зүйлсээ хэлтэс нэгжийн хурал, цуглаан дээр танилцуулах. • Дээд албан тушаалтны ажлын нэг хэсгийг орлож ажиллах хэмжээний чадвартай болох

	Үйлчлүүлэгчийг эрхэмлэсэн харилцааны чадвар	Үйлчлүүлэгчийн өнцгөөс харж, үйлчлүүлэгчид итгэл төрүүлэх яриаг сонсон, аль аль талын сэтгэлд нийцэхүйцээр шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> Үйлчлүүлэгчийн яриаг сайтар сонсон, "Асуудал шийдэх хамтрагч" гэсэн итгэл төрүүлэх Үйлчлүүлэгчид авах арга хэмжээг нэгдүгээрт тавих Цэвэрч нямбай, зөв гадаад төрх, эерэг хандлагатайгаар ажиллаж үйлчлүүлэгчид зөв сэтгэгдэл төрүүлэхгүй байх. Талуудын яриаг эрх тэгш сонсож, талуудын үзэл бодлыг хүндлэнгээ тохиромжтой шийдвэрлэх аргыг олох. 	<ul style="list-style-type: none"> Үйлчлүүлэгчийн яриаг сайтар сонсон, "Асуудал шийдэх хамтрагч" гэсэн итгэлийг олох Үйлчлүүлэгчид авах арга хэмжээг нэгдүгээрт тавих Үйлчлүүлэгчид зөв сэтгэгдэл төрүүлэхгүй гадаад төрх, хандлагатайгаар ажиллах Осолтой холбоотой бүх хүмүүсийг гомдоохгүйгээр асуудлыг шийдэх гарцыг олохын тулд арга хэмжээ авч, сэтгэл ханамжтай үлдээх нөхцөлийг бүрдүүлэх.
--	---------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Албан тушаал	Чадамж	Тайлбар	Агуулга шаардлага/ /үндсэн
Оператор	Үнэт зүйл	Компанийн үнэт зүйлийг мэддэг бөгөөд үүнд тохирсон үйл ажиллагааг явуулах	Компанийн философи, алсын хараа, эрхэм зорилгыг ойлгодог байх • Өөрөө сайтар ойлгосны үндсэн дээр дагалдан ажилтанд өөрийн үйлдэл, заавраар дамжуулан ойлгуулж, компанийн үнэт зүйлд нийцсэн үйлдлийг хийлгэх • Компанийн нийгмийн хариуцлагыг ойлгож үүнд нийцсэн үйлдэл хийдэг байх.
	Үүрэг хариуцлага	Өөрийн хариуцлагын хүрээг мэддэг	"Ослын дуудлага хүлээж авснаас хойш, даатгуулагчид нөхөн хариуцлага гэдгийг мэддэг байх. зохистой түвшинд байлгахад өөрийн хувь нэмрийг оруулж, х
	Ажил гүйцэтгэх чадвар	Үүрэг хариуцлагын хүрээнд хийх ажлын гүйцэтгэл	Ажлын үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэхийн тулд тасралтгүй арга хэмжээ авч байх • Компанийн дотоод, гадаад төрөл бүрийн нөөцүүдийг ашиглаж чаддаг байх.
	Мэдлэг	Ажлын гүйцэтгэлд хэрэгцээтэй бүх мэдлэгийг сурч, ажилдаа хэрэглэх	Хууль, дүрэм, журам, Даатгалын бүтээгдэхүүнүүд, Нөхөн төлбөрийн үйл ажиллагаа, ДК уудын хаяг байршил, холбогдох утасны дугаарууд, Мэдээллийн технологи, Авто замын схем, хаягжилтийн мэдлэг өндөр байх, Ослын нөхцөл байдал, онцгой тохиолдол зэргийг бүрэн эзэмшиж, гэнэтийн нөхцөл байдалд арга хэмжээ авч чаддаг байх. /Түргэн тусламж дуудах, Цагдаа дуудах/
	Шийдвэрлэх чадвар	Тохиромжтой хариу, зөвлөгөө өгөх	Ослын дуудлагын зохицуулалтыг зөв оновчтой шийдвэрлэх гарцыг мэддэг байх. Онцгой тохиолдлуудын туршлага хуримтлуулан арга хэмжээ авч чаддаг байх.
	Өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх тэмүүлэл	Өөрийгөө хөгжүүлж, компанийн гүйцэтгэлд хувь нэмрээ оруулмаар байна гэсэн тэмүүлэлтэй байхаас гадна, тэрийгээ үйлдэл болгодог байх.	<ul style="list-style-type: none"> Дараа жилийн эзэмших ёстой мэдлэгээ ямар аргаар сурах вэ гэдгээ төлөвлөж, менежерээр дүгнүүлэх Суралцахаа үргэлжлүүлж, тогтмол хугацаанд засаж, залруулж байх Өөрийн туршлагаасаа дагалдан ажилтан, операторт зааж сургах, өөрийн сурсан зүйлсээ хэлтэс нэгжийн хурал, цуглаан дээр ярих. Дээд албан тушаалтны ажлын нэг хэсгийг орлож ажиллах хэмжээний чадвартай болох
Үйлчлүүлэгчийг эрхэмлэсэн харилцааны чадвар	Үйлчлүүлэгчийн өнцгөөс харж, үйлчлүүлэгчид итгэл төрүүлэх, дуу хоолойны өнгийг даатгуулагчид хангалттай сонсогдохуйц хэмжээнд байлгаж, тод ойлгомжтой үгээр үйлчлүүлэгчийг хүндлэн найрсаг харьцана.	<ul style="list-style-type: none"> Үйлчлүүлэгчийн яриаг хүлээцтэй сайтар сонсон, "Асуудал шийдэх хамтрагч" гэсэн итгэл төрүүлэх Үйлчлүүлэгчид авах арга хэмжээг нэгдүгээрт тавих Цэвэрч нямбай, сэргэлэн цовоо, эерэг хандлагатайгаар ажиллаж үйлчлүүлэгчид зөв сэтгэгдэл төрүүлэхгүй байх. Осолтой холбоотой бүх хүмүүсийг гомдоохгүйгээр асуудлыг шийдэх гарцыг олохын тулд арга хэмжээ авч, сэтгэл ханамжтай үлдээх нөхцөлийг бүрдүүлэх. 	

2. Дунд шатны удирдлагын ажилтанд шаардлагатай манлайлал болон коучинг хийх

Коучинг аргыг ашиглаж компанийн ажилтан тус бүртэй ганцаарчилсан дэлгэрэнгүй ярилцлага хийж үнэлгээний зөрүүг тодорхойлсон. Зөрүүг багасгахын тулд хувь хүнийг хөгжүүлэх сургалтын төлөвлөгөөг боловсруулж сургалтад хамруулан ажиллаж байна.

3. 5S хөдөлгөөний хэрэгжүүлэлт

5S-ыг хэрэгжүүлэх баг бий болгож, ажлын төлөвлөгөө төсөвтэй болгосон. 5S хөдөлгөөнийг аяны хүрээнд оффис болон компанийн нэгдсэн агуулахыг эмх цэгцтэй болгож тохижуулсан. Үүний үр дүнд агуулахад байгаа эд зүйлсийг компани тус бүрээр өнгөөр ялган ангилж, хаягжуулан цэгцэлж талбайн ашиглалтыг оновчтой зөв хуваарилснаар цаг хэмнэх зэрэг олон эерэг үр дүнгүүд гарсан. Цаашид манай компанийн шинээр хэрэгжүүлж буй автомашины оношилгоо, тос тосолгоо, агрегат, кузов засвар, угаалга, сэлбэг хэрэгслийн худалдааны зэрэг цогц үйлчилгээ үзүүлэх “АвтоХАБ” төслийн үйл ажиллагаанд 5S хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

3. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл

1. Япон ажилтнууд ажилдаа өөриймсөг, чин сэтгэлээсээ хандаж компанидаа урт хугацаанд тогтвортой ажиллаж байгаагааг судалж, суралцсан:

- Ажилтнуудыг компани, ажилдаа өөриймсөг хандаж ажиллуулахын тулд ажил олгогч, ажилтан гэсэн ойлголтыг халж хамтран ажиллагчид гэсэн ойлголт, соёлыг бий болгох; (Хожо багшийн лекц)
- Хүний хамгийн үнэ цэнэтэй зүйл бол гэр бүл, тиймээс ажилтуудын хувийн зорилгыг компанийн зорилготой уялдуулах (Ажилтнуудаар амьдралын төлөвлөгөө хийлгэх, Гогёофүкү компани)
- Компанийнхаа Кредо-г гаргаж ажилтнуудад байнгийн үзэж харж, уншиж байхад боломжтой байдлаар хийх (Ингэснээр компанийнхаа үнэт, зарчим, эрхэм зорилго зэргээс урам зориг авч урт хугацааны алсын хараатай ажилладаг, Коганэяа Шокүхин, Гогёофүкү, бусад компаниуд)

2. Япон улсын үйчилчлэгээний стандарт болон үйлчилгээний соёл, баримталж буй зарчим зэргийг суралцаж компанидаа нэвтрүүлэх:

- Үйчилгээний ажилтнуудын албан тушаал бүр дээр тохирсон үйчилгээний стандартууд боловсруулж баталж мөрдүүлэх (Үйлчлүүлэгчид хэрхэн үйчилгээ үзүүлэх талаар, AP company)
- Сургалтууд тогтмол хийж ажлын ажлын процесийн заавар гаргаж байнга харж байхаар газар байршуулах

3. Удирдах албан тушаалтнуудынхаа манлайлал санаачилгыг сайжруулж, ажилтнуудын бүтээмжийг жигд нэмэгдүүлэх асуудал тулгарч байгааг шийдэх:

- Судалгаанууд сайн хийж ажилтнуудаа маш сайн таних (Сэтгэл зүйн талын, Сэтгэл ханамж-EIS, 360 градус ... ярилцлага). Сонирхолд нь суурилсан (ажиллах салбар, газрыг нь өөрөөр сонгуулах), чадамжид нь тохирсон ажил хийлгэх (AP company); Ажилтнуудынхаа сайн туршлагыг бусадтай хуваалцах
- Ажилтнуудаа үргэлж шинийг санаачлагч байх тогтолцоог бүрэлдүүлэх (Sunpac, Гогёофүкү: 14 төрлийн шалгуураар дүгнэж шадгаруулдаг)
- Гүйцэтгэлийн үнэлгээний системдээ эдийн зэсгийн аргаас гадна сэтгэл санааны, сэтгэл хангалуун байлгах аргуудыг түлхүү хэрэглэх. (AP company, Хожо)

4. Шинэ технологи, инноваци, үйл ажиллагааны процессийг хэрхэн зохион байгуулж, програмчилж, автоматжуулах:

- Бүх мэдээ мэдээлэл, материалууд дижитал болж байгаа болохоор эдгээр мэдээллийг эмх цэгцтэй аюулгүй зохион байгуулах, цаашлаад бүх мэдээллийг уялдаа холбоотой нарийн програмчлах (RICOH, Toyota L&P)
- 7 Мүдэг тодорхойлон илрүүлж, болон 5S аргыг улам боловсронгуй болгож хэрэгжүүлэх; (Хөдлөхийг Ажиллах болгож өөрчлөх, Алдаа доголдлыг шууд илрүүлэх – Toyota L&P, RICOH)
- Засварын газрын сургалтын материалыг VR буюу вертуал хэлбэрээр бэлдэж ажилтнууддаа сургах (Toyota үйлдвэр)

4. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

Богино хугацаанд маш өндөр зохион байгуулалттайгаар олон төрлийн компаниудаар оруулж, тэдгээрийн хэрэгжүүлж буй менежментийн арга барилыг онол, практик хослуулан заасан нь ихээхэн үр дүнтэй байсан бөгөөд сурсан мэдсэн зүйлээ хэрхэн компани дээрээ хэрэгжүүлж байгаа талаар эргэх холбоотой ажиллаж байгаа нь үр дүнг улам сайжруулж байна.

5. Сургалтын талаарх сэтгэгдэл, компани хэрэгжүүлж болохуйц жишээ

- Ажилтнуудыг компани, ажилдаа өөриймсөг хандаж ажиллуулахын тулд ажил олгогч, ажилтан гэсэн ойлголтыг халж, хамтран ажиллагчид гэсэн ойлголт, соёлыг бий болгох;
- Компанийнхаа Кредо-г гаргаж ажилтнуудад байнгын үзэж харж, уншиж байхад боломжтой байдлаар хийх. Ингэснээр компанийнхаа үнэт, зарчим, эрхэм зорилго зэргээс урам зориг авч урт хугацааны алсын хараатай ажилладаг;
- Ажилтнуудаар амьдралын төлөвлөгөө хийлгэх - Хүний хамгийн үнэ цэнэтэй зүйл бол гэр бүл, тиймээс ажилтнуудын хувийн зорилгыг компанийн зорилготой уялдуулах;
- Ажилтнуудаа үргэлж шинийг санаачлагч байх тогтолцоог бүрэлдүүлэх. Тодорхой шалгуур үзүүлэлтүүд гаргаж шинэ санал санаачилгыг шалгаруулдаг болох;
- 7 Мүдэг тодорхойлон илрүүлдэг тогтолцоо бий болгож, Хөдлөхийг Ажиллах болгож өөрчлөх;

6. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани эсвэл өөрийн бие дээр)

- Бүх компаниудын хэмжээнд менежментийн шинэчлэл хийх, толгой компани болон түүний охин компаниудын бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх, удирдах түвшний албан тушаалууд (Гүйцэтгэх захирлууд, газрын дарга нар) дээр дахин томилгоо хийх (хооронд нь солих эсвэл гаднаас шинээр хүмүүс авч томилох) цаг болоод байгаа тул үүнийг хэрхэн төлөвлөж, зөв гүйцэтгэх
- Гүйцэтгэх удирдлагууд болох охин компанийн захирлууд, газрын дарга нарийнхаа манлайлал, бүтээмжийг жигд нэмэгдүүлэх
- Автомашины засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгслийн худалдааны бизнесүүдэд хэрэгжүүлж байгаа шинэ технологи, инноваци, үйл ажиллагааны процессийг хэрхэн зохион байгуулах


7. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

- Бизнесийн философи, үзэл баримтлал, баримтлаж буй зарчим зэрэг хэлбэрээс илүү агуулга талыг нь судлах чухал.
- Сурч мэдсэн зүйлүүдээ өөрийн компани дээр хэрэгжүүлэхдээ хэт богино хугацаанд үр дүн гарна гэж амархан хүлээлт үүсгэлгүй урт хугацаанд тууштай, төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх.

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв

Нэр: Х.Гармаабазар

Албан тушаал: Ерөнхий удирдлагын тасгийн дарга



Байгууллагын нэр:	Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв
Байгуулагдсан он:	2002
Үйл ажиллагааны чиглэл:	Боловсрол
Ажилтны тоо:	28

Байгууллагын товч танилцуулга

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв нь Монголын зах зээлийн эдийн засагт хувь нэмэр оруулахуйц хүний нөөцийг хөгжүүлэх, Монгол, Япон хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА, БСШУЯ болон МУИС-ийн хамтарсан төсөл хэлбэрээр 2002 оноос үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Одоо бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх, япон хэлний боловсрол, хамтын ажиллагаа гэсэн үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв нь ЖДҮ-ийг хөгжүүлэх зорилготой ба арвин туршлагатай япон, монгол багш нар төрөл бүрийн бизнесийн сургалт, семинарыг зохион байгуулдаг. Мөн олон жилийн туршид монгол компаниудтай бий болгосон сүлжээгээрээ дамжуулан монгол, япон компанийн бизнесийн харилцааг дэмжин ажиллаж байна.

1. Монгол-Японы төвийн сургалтаар сурсан зүйлээ байгууллагадаа яаж хэрэгжүүлж байна вэ? Гарсан өөрчлөлтийн талаар

Суралцсан зүйл

- Хүний нөөцийн удирдлагын сургалтаас хүний нөөцийг хөгжүүлэх, хүний нөөцийн япон менежментийн ухаанаас суралцсан.
- Япон маягийн менежментийн үндэс болсон 5S кайзэн сургалтаас ажлын бүтээмж дээшлүүлэхэд шаардлагатай арга, аргачлалыг суралцсан.

Хэрэгжүүлж буй байдал

- Ажилтны сургалт хөгжлийн жил бүрийн төлөвлөгөөг боловсруулдаг, ажилтны мэргэжил дээшлүүлэх журмыг батлуулсан, эрүүл мэнд спортын арга хэмжээний жилийн төлөвлөгөө гарган эдгээрийг хэрэгжүүлж байна.
- 5S кайзэн баг, 5S кайзэн хөдөлгөөний жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, нийт ажилтнуудын оролцоог хангахыг зорьж ажилладаг.

Цаашид хэрэгжүүлэх ажлууд

- Ажилтны төлөвлөлт, төлөвлөгөө боловсруулах чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, карьер хөгжлийн төлөвлөгөө, чадамжийн толь боловсруулах
- 5S кайзэн хөдөлгөөнийг тасралтгүй, тогтвортой, илүү үр дүнтэй хэрэгжүүлэх, байгууллагын хөгжилд чиглэсэн үйл ажиллагаа

Тулгарч буй асуудал, түүнийг шийдвэрлэх талаар

- Хэрэгцээ шаардлагыг тодорхойлж ажилтны сургалт хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлдэг. Цаашид ажилтны ур чадварыг хөгжүүлэх, ажилтны карьер хөгжлийг тусгах, илүү үр дүнтэй ач холбогдол өндөртэй төлөвлөгөө боловсруулах, тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай.
- 5S кайзэн хөдөлгөөнийг хэрэгжүүлж ирсэн боловч дахин давтах, шаардлагаа гардаг, ахиц харьцангуй бага байна гэж дүгнэгдэж байгаа. Илүү үр дүнтэй байх хэрэгжүүлэлтийн арга

барилыг нэвтрүүлэх, тогтвортой тууштай байдлыг хангах, дадал хэвшил болгох шаардлагатай.

2. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл

- Япон маягийн менежментийн ойлголтоо гүнзгийрүүлэн судалж, Японы компаниудын бодит байдал, практикаас суралцах
- Хүний нөөцийн тогтолцоог хөгжүүлэхэд шаардлагатай шинэ мэдээлэл олж авах, мэдлэг ноу-хау эзэмших
- 5S кайзэн хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай шинэ мэдээлэл, мэдлэг, ноу-хау олж авах

Хүний нөөцийг хөгжүүлэх талаар

- Хүнд ээлтэй менежмент /Хоожоо профессор/

Five real philosophy, ажилтнууд өөрсдөө санаачлан өөрсдөө хийж гүйцэтгэх

- Байгууллагын хөгжил ба хүний нөөцийн сургалт, хөгжүүлэлт /AP/

Залуу ажилтнуудын хөгжүүлэлт

- Бүтээгдэхүүн хөгжүүлэлт ба хүний нөөцийн хөгжил /Sunpac/

Асуудал шийдвэрлэх чадвар, бүтээлч сэтгэлгээ

- Менежментийн философи, маркетинг /Koganeya/

Удирдлагын манлайлал

- Менежментийн стратеги, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж /Kansai home service/

Бүх зүйл үйлчлүүлэгчдээс, тэдний сэтгэл ханамжаас эхтэй

- Менежментийн төлөвлөгөө, ажиллагсдын сэтгэл ханамж, брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэлт /Dreams/

Friendly service manner

5S кайзэн хөдөлгөөний талаар

- Тоёота хэлбэрийн 4S-ийг хэрэгжүүлэх нь /Toyota L&F/

7 муда, Seiri-Seiton-Seisou-Seiketsu+Shitsuke

- Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа /Tokyo Petbottle Recycle/

Аливаа зүйлийг боломж болгох ухаан

- Тоёотагийн үйлдвэрлэлийн аргачлал /Toyota motors/

Бүхнийг нүдэнд ил тод харуулах байдал

- Менежментийн философи, маркетинг /Gogyofuku/

Маркетинг бол сонирхолтой байдлаар хүнийг баярлуулах

- Ажлын байранд хэрэгжүүлэх кайзэн, 3S хөдөлгөөн /Ricoh/

Ажилтнуудын санал, санаачилгыг хөгжүүлэх

- Онол, зарчимд үндэслэсэн кайзэн хөдөлгөөнийг хэрэгжүүлэх арга /Минакава профессор/

Кайзэн хөдөлгөөн-зорилгоор удирдах

Бизнес уулзалт

- Токио хот
- Осака хот

3. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

16 жилийн өмнө төвийн үйл ажиллагааг эхлүүлэхээр Япон дахь дадлага сургалтад хамрагдаж байсан. Энэ удаа хийж ирсэн ажлаа, үйл ажиллагаагаа сайжруулахаар бизнесийн сургалтын төгсөгч-компанийн удирдлагууд шилдэг хүмүүстэй сургалтад хамрагдсандаа их өндөр сэтгэгдэлтэй байна. Ийм боломж олгосон холбогдох байгууллага ЖАЙКА, Рело Панасоник Интернэйшнл, Прекс-ийн хариуцсан албаны хүмүүс, төвийнхөө удирдлагад талархал илэрхийлье. Японы компаниудаас их зүйл сурч мэдэж авлаа. Үүний зэрэгцээ энэхүү сургалтын хөтөлбөрт хамтарч ажилласан ЖАЙКА, Рело, Прекс-ийн нягт хамтын ажиллагаа, зохицуулагч Үчида гуайн орчуулга хийж, бичиж тэмдэглэж буй байдлаас ч их зүйл ажиглаж мэдэж авсан. Сургалт заасан профессор, захирлуудаас болон айлчилсан япон компаниуд дээр маш их зүйл сурч мэдэж, заалгаж авлаа. Энэ удаагийн сургалтын онцлог нь бизнесийн уулзалтыг 2 удаа зохион байгуулсан явдал юм. Монгол, японы компаниудын удирдлагууд уулзаж, харилцан мэдээлэл солилцсон үр дүнтэй үйл ажиллагаа болсон. Хамгийн сэтгэгдэл төрүүлсэн зүйл бол 10 хүртэлх ажилтантай японы компанийн эмэгтэй захирал, удирдлагуудын менежментийн, удирдахуйн арга ухаан байлаа.

4. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

Action plan ①

“DEKIRU” буюу чаддаг ажилтны сургалт хөгжлийн төлөвлөгөө

2018 оны 10-р сараас бэлтгэл ажлаа эхлэн үргэлжлүүлэн хэрэгжүүлэх:

2018 оны 10-р сар Уулзалт ярилцлагын хэлбэрээр ажилтан бүрийн хүсэлт, зорилго төлөвлөгөөг судлах

2018 оны 11-р сар Тасгийн дарга нартай хамтран төлөвлөгөөний төсөл боловсруулах, шаардлагатай төсөв зардал тооцох, төслөө удирдлагадаа танилцуулж шийдвэрлүүлэх

2018 оны 12-р сар Судалгаа, төлөвлөгөөний төслөө дахин нягталж хянах

2019 оны 1-р сар Хэрэгжүүлж эхлэх

Action plan ②

“KAIZEN” 5S кайзэн хөдөлгөөн

2018 оны 10-р сараас бэлтгэл ажлаа эхлэн үргэлжлүүлэн хэрэгжүүлэх

2018 оны 10-р сар Кайзэн багийнхантай хамтран судалгаа хийх, зорилго тодорхойлох

2018 оны 11-р сар Кайзэн багийнхантай үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл боловсруулах, шаардлагатай төсөв зардал тооцох, төслөө удирдлагадаа танилцуулж шийдвэрлүүлэх

2018 оны 12-р сар Судалгаа, төлөвлөгөөний төслөө дахин нягталж хянах

2019 оны 1-р сар Хэрэгжүүлж эхлэх

5. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани эсвэл өөрийн бие дээр)

Энэ удаа дараах 2 асуудлыг гаргаж тавьж, сайжруулах зорилго тавьсан. Одоог хүртэл хэрэгжүүлж байгаа

- Ажилтнуудын сургалт, хөгжлийн төлөвлөгөөг сайжруулах
- 5S кайзэн үйл ажиллагааг сайжруулах

Дадлага сургалтаар айлчилсан япон компанийн тухай олон удаа сонсож байсан зүйлээ өөрийн биеэр компани дээр нь очиж, нүдээр харж, чихээр сонсож их зүйл мэдэж авлаа.

Ялангуяа японы компаниудаас байгууллагынхаа үнэт зүйл болсон хүний нөөцийн сургалт, хөгжилд маш их анхаарч нухацтай ханддагийг суралцаж, бодит байдал дээр харж мэдэж авлаа.

Манай төв япон маягийн менежментийн ажлын арга барил, зарчим болох хоорэнсоо буюу мэдээлэх, холбоо барих, зөвлөлдөх аргын талаар сургалт явуулаад оролцогчдын санал сэтгэгдэл өндөр гарсан боловч яг ажил дээрээ цаг тухайд нь мэдээлэхгүй байх байдал хэвээрээ, давтагддаг. Үүнээс бид мэдээлэл түгээгээд, мэдлэг олгоод байдаг юм байна, чаддаг болтол нь сургах нь чухал гэдгийг ойлгосон. Нөгөө талаас ажилтан маань сурч мэдээд, чаддаг болсноороо өөртөө итгэлтэй болж, ажиллах урамтай болохын тулд сургалт хөгжүүлэлтийн төлөвлөгөөг сайжруулахыг зорин ажиллана.

5S кайзэн хөдөлгөөнийг хэрэгжүүлж ирсэн, одоо ч үргэлжлүүлэн хэрэгжүүлдэг. Ажлын бүтээмжээ дээшлүүлэх сайжруулах зүйл олон байгаа тул сургалтаас суралцсан мэдлэгээ ашиглан Накамүра мэргэжилтний заавраар “Кайзэн кайзэн бас дахин кайзэн” буюу улам сайжруулан ажиллана.

Тухайлбал, хамгийн их хийгддэг ажил болох бичиг баримт боловсруулахад тухайн бичиг баримтын хуудас, ашигласан програм, файлын хэлбэр зэрэг нь ялгаатай байдаг байдал түгээмэл тул цаг хэмнэж, хялбар болгож, алдаагүй, бүтээмж өндөр хийх үүднээс нийтлэг шаардлагатай бичиг баримтыг загварчлах, тэмплэйт бэлтгэх зэргээр төлөвлөж байна.

6. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Япон дахь дадлага сургалтад хамрагдахаар төлөвлөж байгаа бол урьдчилан судлах, мэдээлэл ихээр хуримтлуулж, төлөвлөгөө гарган, бэлтгэлээ сайн хангаж ажиллах шаардлагатай бөгөөд дараах зүйлүүдийг анхаарахад илүүдэхгүй болов уу.

- Компанийхаа болон хувийн ажлын төлөвлөгөөгөө сайтар гаргасан байх, хувийн бэлтгэлээ урьдчилсан байдлаар маш сайн хангах
- Дадлага сургалтаар сурах зүйлээ, зорилгоо тодорхой болгох, дахин дахин нягтлах
- Эргэж ирээд дадлага сургалтаар уулзаж танилцан, харилцаа тогтоосон япон хүмүүстэй харилцаагаа үргэлжлүүлэх